APU COMPANY
Absolute Pure Unique




# ЖИЛИЙН ТАЙЛАН 2024

# 01

## БИДНИЙ ТУХАЙ


Товч түүх 6 - 7
Эрхэм зорилго 9
Алсын хараа 9
Үнэт зүйлс 9
Далдал хэвшил 9


# 02

## БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА


ТУЗ-ийн даргын захидал 12
Гүйцэтгэх захирлын захидал 14
2024 оны үйл ажиллагааны хураангуй 15
2024 оны санхүүгийн үйл ажиллагааны ерөнхий тойм 17
Онцлох үйл явдал 18 - 25
2024 оны экспортын онцлох үйл явдал 26 - 27
Бүтээгдэхүүн хөгжүүлэлт 28
Зах зээлийн нөхцөл байдал 29
Гүйцэтгэх удирдлагын баг 30
АПУ Групп компанийн бүтэц 31
Үйлдвэрлэл, үйл ажиллагаа 32 - 35
Хүн төвтэй засаглал 36 - 41

# 03

## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ


Компанийн ерөнхий мэдээлэл 44
Хувьцаа эзэмшигчид 44 - 45
Төлөөлөн удирдах зөвлөл 46 - 55
Хувьцааны мэдээлэл 56 - 57
Ногдол ашгийн мэдээлэл 58
Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт 59


# 04

## ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ


Тогтвортой хөгжлийн стратеги 62 - 63
Ямагт орших өв соёл 64
Ногоон ба цэвэр тунгалаг 65 - 67
Хүчирхэгжсэн хамт олон 68 - 69
Баялаг, Хариуцлагатай 70 - 71
Тогтвортой түнш 72 - 73


# 05

## САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ


Дэлгэрэнгүй орлогын тайлан 76
Санхүү байдлын тайлан 77
Мөнгөн гүйлгээний тайлан 78 - 79
Өмчийн өөрчлөлтийн тайлан 80
Тайлагналын зарчим 81 - 83
Тайлбар толь 84



# 01



# БИДНИЙ ТУХАЙ

Товч түүх

Эрхэм зорилго

Алсын хараа

Үнэт зүйлс

Дадал хэвшил

# 1924

## 1924

Зүүн сэлбийн баруун хөвөөнд таван Монгол, есөн Орос ажилтантай, архи найруулах, савлах гар ажиллагаатай үйлдвэрийг ашиглалтад оруулав.



## 1927

Шар айргийг Чех улсын мэргэжилтнүүдийн тусламжтайгаар Монголчууд анх удаа дотооддоо үйлдвэрлэж эхлэв.



## 1961

Ундаа хийжүүлэх, хэнд бэлтгэх Болгар улсын тоног төхөөрөмжтэй ундааны цех байгуулав.



## 1974

Монголд үйлдвэрлэсэн шар айргаа гадаадад экспортолж эхлэв.



## 1988

"Оргилуун" брэнд шинээр мэндлэв. Ундааг 0.33 литрийн шилэн саванд савлах 12 мянган лонхцагийн хүчин чадалтай урсгал шугам бүхий ундааны 2-р үйлдвэрийг шинээр байгуулав.



## 1992

Архи Пивоны комбинатыг АПУ хувьцаат компани болгон зохион байгуулж, нийт хувьцааны 51 хувь төрийн мэдэлд, 49 хувь нь Монголын хөрөнгийн биржээр арилжаалагдсан.



## 2001

"АПУ ХК"-ийн нийт хувьцааны төрийн мэдэлд байсан 51 хувийн хувьцааг нийтийн дуудлага худалдаагаар арилжсанаар "АПУ ХК" хувийн өмчид бүрэн шилжив.



## 2009

ХБНГУ-ын "Шмитт" компанийн орчин үеийн дэвшилтэт технологиор бүрэн тоноглогдсон "Альфа" буюу тансаг зэрэглэлийн спирт үйлдвэрлэх "Натур Агро" хүчийн үеийн нэрэх үйлдвэрийг ашиглалтад оруулсан.



## 2014

Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлэгч Германы GEA компанитай хамтран шинэ сүүний үйлдвэрийг ашиглалтад оруулав.



## 2021

АПУ компани Монголын анхны нэг их нийд тэгрэгийн үнэлгээтэй олон нийтийн компани болж, хүн төвтэй засаглалын бодлогыг шат дараатай амжилттай хэрэгжүүлж "Ажиллахад таатай газар" олон улсын сертификатыг Монгол улсдаа анх удаа гардан авав.



## 2024

АПУ компанийн улс эх орондоо оруулсан хувь нэмрийг үнэлэн, Монгол Улсын Ерөнхийлөгч зарлиг гарган "Хөдөлмөрийн гавьяаны улаан туг одон"-оор шагнав.



Урт хугацааны зорилготой уялдсан тогтвортой хөгжлийн нөлөөллөө цар хүрээ, тэлэх чиглэлийн хувьд оновчилж, Бахархалт Монгол/ Тогтвортой хөгжлийн стратеги 2030-ыг баталлаа.



## 2017

Нидерландын HEINEKEN компанийн Монгол дахь ээмшлийн компаниудыг (М-БИ-СИ Азиа Пасифик ХХК, Спирт Бал Бурам ХХК, СББ Трейд ХХК) өөртөө нэгтгэн хүчирхэг нэгдлийг бий болгов.



## 2023

Уламжлалт технологийг орчин үеийн тоног төхөөрөмжтэй хослуулан бүтээж, "Монгол бяслаг, Шигүдэри" үрлэх үйлдвэрийг ашиглалтад оруулж, Хонин нуга брэндийг худалдаанд гаргалаа.



## 2024

Нидерландын дэлхийд алдартай Хайнекен шар айргийг олон улсын стандартын дагуу АПУ компани цор ганцаар нь дотоодод үйлдвэрлэж эхлэв.





ALWAYS FORWARD

# ҮРГЭЛЖ ӨӨДӨӨ

## ЭРХЭМ ЗОРИЛГО

Шинэ санаачилга, бүтээх тэмүүллээр урлаж буй бүхэндээ үргэлж сэтгэлээ шингээнэ

## АЛСЫН ХАРАА

Дэлхийд танигдах эрхэм Монгол хүмүүний оюун чадвар, ур ухаан, шинэчлэл, тогтвортой хөгжлийн үндэслэгч байя

## ҮНЭТ ЗҮЙЛС

**ТАНИХ ЭРМЭЛЗЭЛ**

**ЭРЭЛ, ХАЙГУУЛЧ СЭТГЭЕ**
Тасралтгүй шинийг эрэлхийлж, суралцаж, хуваалцаж, туршъя.

**ҮНЭН ЧАНАР**

**ХАМТДАА ЯЛЬЯ**
Чанарыг эрхэмлэж, ялалтын сэтгэлгээгээр урагшлая

**БҮТЭЭЛЧ ЧАДВАР**

**ИННОВАЦИЛАГ АЖИЛЛАЯ**
Уламжлалаа хүндлэж, шинийг бүтээе

**ХҮНЛЭГ СЭТГЭЛ**

**ХҮНДЛЭН ЭРХЭМЛЭЕ**
"Хүн" байхыг чухалчилж, сайн сайхныг түгээе.



# 02



# БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ТУЗ-ийн даргын захидал
Гүйцэтгэх захирлын захидал
2024 оны үйл ажиллагааны хураангуй
2024 оны санхүүгийн үйл ажиллагааны ерөнхий тойм
Онцлох үйл явдал
2024 оны экспортын онцлох үйл явдал
Бүтээгдэхүүн хөгжүүлэлт
Зах зээлийн нөхцөл байдал
Гүйцэтгэх удирдлагын баг
АПУ Групп компанийн бүтэц
Үйлдвэрлэл, үйл ажиллагаа
Хүн төвтэй засаглал



## ТУЗ-ИЙН ДАРГЫН ЗАХИДАЛ

Та бүхэндээ АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нэрийн өмнөөс 2024 оны санхүү, үйл ажиллагааны үр дүнг танилцуулан, мэндчилж байна.

Өнгөрсөн онд хамт олны маань хүч хөдөлмөр, өндөр гүйцэтгэлийн ачаар бидний тавьсан зорилтууд биелж, борлуулалтын хэмжээ, орлогоо нэмэгдүүлэн ажиллалаа. АПУ компани хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг дээдлэн, сүүлийн 10 жилд тасралтгүй ногдол ашиг тарааж, хөрөнгийн зах зээлийг манлайлсаар ирсэн. Энэ уламжлалаа хадгалан, 2024 оны санхүүгийн үр дүнгээр нийт 127.7 тэрбум төгрөг буюу нэгж хувьцаанд 120 төгрөгийн ногдол ашгийг хоёр удаагийн шийдвэрээр хуваарилсан байна.

Монгол Улсын ууган үйлдвэр болох АПУ компанийн түүхт 100 жилийн ойн хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөлөөс бүх ажилтандаа хувьцаа эзэмшүүлэх шийдвэрийг гаргасан. Энэ санаачилгыг Шунхлай группийн оролцогч бүх компани дэмжин, нийт 8000 гаруй ажилтнуудаа хамруулсан билээ. Ийнхүү 2024 оны жилийн эцсийн байдлаар АПУ компанийн хувьцаа эзэмшигчдийн тоо 32 мянга орчим болж, Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудаас эхний дөрөвт бичигдэж байна.

2025 оноос эхлэх шинэ эрин үед АПУ компани бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, бүхий л үйл ажиллагаандаа шинэ санал санаачилгыг дэмжин, "Бахархалт Монгол" тогтвортой хөгжлийн стратегийнхаа тулгуур багануудыг бэхжүүлж, байгууллагын үнэт зүйлсийг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэвшил болгож, эрхэм зорилгоороо удирдуулан салбарын хөгжлийг манлайлж, дэлхийн зах зээлд гарах хүчин чармайлтаа эрчимжүүлнэ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн нэрийн өмнөөс АПУ компанийн гүйцэтгэх удирдлагын баг, нийт хамт олондоо нэгэн зорилго дор нэгдэж, гүйцэтгэлээр манлайлан ажиллаж буйд талархал илэрхийлье.
Мөн эрхэм хувьцаа эзэмшигчид болон хэрэглэгч, харилцагчид та бүхэндээ бидэнд итгэл хүлээлгэн, үргэлж дэмжиж ирсэнд чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Хүндэтгэсэн,
Пүрэвийн **Батсайхан**


1924
100 YEARS
2024
1958
APU
COMPANY
Нийслэл
БОРГИО



## ЭРХЭМ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, ХАРИЛЦАГЧ, ХАМТРАГЧ ТҮНШ БАЙГУУЛЛАГУУД, ХҮНДЭТ ХЭРЭГЛЭГЧ ТА БҮХНИЙ АМГАЛАНГ ЭРЭН МЭНДЧИЛЬЕ.

2024 он бидний хувьд түүхэн зуун жилийн ойгоо тэмдэглэн өнгөрүүлж, төр засаг, хэрэглэгч түмнээрээ амжилт бүтээлээ үнэлүүлэхийн зэрэгцээ, томоохон бүтэн байгууламж, соёл, бодлогын шинэчлэлтээр дүүрэн жил байлаа.

Зуун жилийн турш бүтээсэн туршлага, хамт олны хичээл зүтгэл, үе үеийн эрдэмтэн мэргэд, технологич инженерүүдийн амжилт бүтээл, компанийн улс эх орондоо оруулсан хувь нэмрийг үнэлэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар "Жаран жилийн гавьяаны улаан тугийн одон"-гоор шагнуулав.

2024 он бидний хувьд өөрчлөлт, өсөлт хөгжил, шинэчлэл дүүрэн жил байсан бөгөөд бизнесийн зорилгоо дараах үндсэн 4 тэргүүлэх чиглэлээр тодорхойлж, өндөр гүйцэтгэлтэй ажиллахыг зорьсон.

**Нэгдүгээрт,** Өсөлтийн бодлого ба зардал үр ашгийн менежментийн шинжилгээнд онцгой анхаарал хандуулж ажилласан.
Segmented P&L буюу зорилтот үр дүнг тодорхойлох аргачлалыг нэвтрүүлж, өртгийн менежментийн CMI FORCE программыг нэвтрүүлсэн ба дэлхийд алдартай NTT Consulting компанитай хамтран ажиллаж 2025-2030 он хүртэлх Дижитал шилжилтийн нэгдсэн стратегийг тодорхойлж баталлаа.
Мөн тогтвортой өсөлтөд хүргэх үйлдвэрлэлийн суурь баазаа өргөжүүлэх томоохон төсөл хэрэгжүүлсэн нь дэлхийд тэргүүлэгч HEINEKEN шар айрагийг стандартын өндөр шалгуур хангаж, Монголдоо үйлдвэрлэж эхэлсэн явдал байлаа.

2024 онд бид шинэ бүтээгдэхүүний туршилт судалгааг онцгойлон эрчимжүүлж, 60 гаруй шинэ брэндийн хөгжүүлэлтийг хийлээ. Сахаргүй, бага градустай RTD буюу коктейлийн төрөлд Eve, Ooze брэндийг зах зээлд шинээр нэвтрүүлсэн ба 100 жилийн ойн хүрээнд онцгой хувилбаруудыг төрөл бүрийн бүтээгдэхүүний шинэчлэлээр дамжуулан зах зээлд гаргасан байна. Алтанговь, Боргио Бок, Сэнгүр радлер шинэ төрөл, сахаргүй Тэрэлж зеро, хүүхдийн сүүний хэрэгцээг нөхөхөд чиглэсэн Baby Shark сахаргүй сүү, жүүсний төрлүүд, Pro+ тэргүүтэй нийт 16 шоо шинэ брэнд, 50 гаруй брэндийн нэмэлт хөгжүүлэлт хийж хэрэглэгчиддээ хүргэжээ.
2024 оны байдлаар экспортын 12 зах зээлд нэвтэрч, олон улсын томоохон үзэсгэлэн, арга хэмжээнд идэвхтэй оролцож, шинэ зах зээлийн боломжийг эрэлхийлж ажиллаж байна. Үүний нэг нь ХБНГУ-д зохион байгуулагдсан дэлхийн хамгийн том шингэн хүнсний Prowein 2024 үзэсгэлэнд Монгол улсаа төлөөлж анх удаа CHINGGIS KHAN брэндээр манлайлан оролцсон билээ. Мөн БНХАУ-ын соошиал медиа платформоор дамжуулан e-commerce-д нэвтрэх үйл ажиллагааг амжилттай эхлүүллээ.

**Хоёрдугаарт,** Хүн нөөцтэй засаглалыг шинэ түвшинд гаргалаа.
Гүйцэтгэлийн үнэлгээг шинэ аргачлалаар тооцож, олон улсын E&Y компанитай хамтарсан төслийн үр дүнд цалин хөлсний тогтолцоог шинэчилж 2500 гаруй ажилтандаа ил тод, шударга тогтолцоотой, олон улсын түвшний ажил олгогч болж хүний нөөцийн бодлогын шинэчлэл хийгээ.
Хүний нөөцийн Nova цахим платформыг байгуулснаар урамшуулал, хангамжийн хялбар, цогц тогтолцоог бий болгоод байна.

**Гуравдугаарт,** Үйлдвэрлэл, үйл ажиллагааны процессын үр ашгийг дээшлүүлж ажилласан.
ESSA аргачлалын дагуу, бизнесийн үйл ажиллагааны үйл явцыг хялбарчлах, оновчлох, бүтээмж дээшлүүлэх автоматжуулах төсөл хэрэгжүүлж тайлагнал дата урсгал, нэгж хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх чиглэлээр өөрчлөлт шинэчлэл хийсэн нь компанийн бүтээмжийг онцгой өсгөсөн жил байлаа.

**Дөрөвдүгээрт,** Тогтвортой хөгжлийн стратегийг боловсруулан баталж, урт хугацааны замын зураглалаа тодорхойллоо.
100 жилийн ойн хүрээнд 2030 хүртэлх "Тогтвортой хөгжлийн стратеги"-ээ батлан, үндсэн 5 чиглэлээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийн цар хүрээ, хүрэх үр дүнг тодорхойлоод байна. Энэ хүрээнд бид 2024 онд байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлэх төслүүдээ эрчимжүүлж, хаягдал ус цэвэршүүлэх байгууламжийн ТЭЗҮ-г баталсан ба сүүний салбарт ногоон үйлдвэрлэлийг эрчимжүүлэхээр ЕСБХБ, АХБ-тай хамтран 40 сая ам.долларын санхүүжилт бүхий бүтээн байгуулалтыг эхлүүллээ. Мөн хүлэмжийн хийн ялгарлыг анх удаа бүх үйлдвэрлэлийн байгууламжийн үйл ажиллагааг хамруулан цогцоор тооцоолох ажлыг эхлүүлсэн юм.

Монгол Улсын хүнсний салбарын 100 жилийн түүхийг хамтдаа бүтээлцэж, хамтын үнэ цэнийг бий болгож ирсэн эрхэм харилцагч, хэрэглэгч, хамт олон, хувьцаа эзэмшигч та бүхэндээ чин сэтгэлийн талархал илэрхийлье.
Цаашид бид дараачийн зуунд дэлхийд өрсөлдөхүйц чанар, хамтын зорилго дор нэгдэн, итгэлцэлд суурилсан хамтын ажиллагаагаа улам бэхжүүлнэ гэдэгт итгэл төгс байна.

Гүйцэтгэх захирал
Цэвээнжавын **ЭРДЭНЭБИЛЭГ**

# 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ

**ЦЭВЭР БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО**
*ТЭРБУМ ТӨГРӨГ*




**БОРЛУУЛАЛТЫН ТОО ХЭМЖЭЭ**
*САЯ ЛИТР*




**ЦЭВЭР АШИГ**
*ТЭРБУМ ТӨГРӨГ*




**ТАТВАР ТӨЛӨЛТ**
*ТЭРБУМ ТӨГРӨГ*




**БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТӨРӨЛ**
*SKU*




**АЖИЛЧДЫН ТОО**




Тэрэлж
Тэрэлж & Сэлэнгэ
Since 1981
New

# 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ТОЙМ

| Тоон үзүүлэлтүүд | Хэмжих нэгж | Аудитлагдсан НСТ 2024 | Аудитлагдсан НСТ 2023 | Өсөлт % |
|---|---|---|---|---|
| **БОРЛУУЛАЛТЫН ТОО ХЭМЖЭЭ** | **мян.литр** | 171,114 | 170,960 | 0% |
| **ОРЛОГО ҮР ДҮН** | | | | |
| Цэвэр борлуулалтын орлого | сая.төг | 1,327,523 | 1,105,352 | 20% |
| Үйл ажиллагааны ашиг | сая.төг | 267,057 | 175,345 | 52% |
| Тайлант үеийн цэвэр ашиг | сая.төг | 192,891 | 117,058 | 65% |
| **БАЛАНС** | | | | |
| Эргэлтийн хөрөнгө | сая.төг | 459,563 | 448,952 | 2% |
| Эргэлтийн бус хөрөнгө | сая.төг | 618,993 | 569,529 | 9% |
| **Нийт хөрөнгө** | **сая.төг** | **1,078,556** | **1,018,481** | **6%** |
| Нийт өр төлбөр | сая.төг | 283,556 | 337,906 | -16% |
| Нийт эздийн өмч | сая.төг | 795,000 | 680,576 | 17% |
| **Нийт эздийн өмч ба өр төлбөр** | **сая.төг** | **1,078,556** | **1,018,481** | **6%** |
| | | - | - | |
| **МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | | | |
| Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | сая.төг | 264,798 | 184,383 | 44% |
| Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | сая.төг | (124,392) | (117,469) | 6% |
| Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | сая.төг | (168,266) | 18,853 | -993% |
| Бусад мөнгөн гүйлгээ | сая.төг | (1,318) | (1,980) | -33% |
| Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | сая.төг | (29,178) | 83,787 | -135% |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **сая.төг** | **122,152** | **38,365** | **218%** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **сая.төг** | **92,974** | **122,152** | **-24%** |
| **ТАТВАР ТӨЛӨЛТ** | | | | |
| Онцгой албан татвар | сая.төг | 244,810 | 236,044 | 4% |
| Нэмэгдсэн өртгийн албан татвар | сая.төг | 105,126 | 90,049 | 17% |
| Бусад | сая.төг | 124,104 | 111,720 | 11% |
| Нийт татвар төлөлт | сая.төг | 474,040 | 437,813 | 8% |
| **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** | | | | |
| Нийт хөрөнгө оруулалт | сая.төг | 112,099 | 109,486 | 2% |




## ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



## "ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНТ" 100 ЖИЛИЙН ТҮҮХТ АПУ КОМПАНИ

АПУ компани 1924 онд байгуулагдсан цагаас хойш цаг үеийн хөгжил дэвшилд манлайлагч байж хөгжин дэвшсээр 2500 гаруй ажиллагсадтай, дотоодын 15 мянга гаруй малчид, тариаланчид, худалдаа, үйлчилгээний салбарын хүндэт харилцагчид болон дэлхийн хэмнээний тоиоохон түншүүдтэй харилцаа холбоогоо бэхжүүлж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шилдэг техник, технологиор урласан брэнд бүтээгдэхүүнээ дотоодын зах зээлд тодийгүй дэлхийн 12 улсад амжилттай экспортолж байна. Ийнхүү зуун жилийн турш бүтээсэн туршлага, хамт олны хичээл зүтгэл, үе үеийн эрдэмтэн мэргэд, технологич инженерүүдийн амжилт бүтээл, компанийн улс эх орондоо оруулсан хувь нэмрийг үнэлэн түүхэн ойн баяр дээрээ Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар "Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон"-гоор шагнууллаа.


YEARS
ТУГИЙН ОДОН



# Centennial Celebration






"Centennial Celebration" түүхт 100 жилийн арга хэмжээнд 20 гаруй улс орноос 150 гаруй гадаадын хамтрагч түнш, харилцагчдын төлөөлөл оролцож, АПУ ХК-ийн хамт олны хамт өргөн дэлгэр тэмдэглэж өнгөрүүллээ.

Бид үйлдвэрлэлийн технологи, тоног төхөөрөмж, түүхий эд материал, инновац, цахим шилжилтийн чиглэлээр олон улсын 3000 гаруй ханган нийлүүлэгчтэй хамтран ажилладаг ба байгальд ээлтэй үйлдвэрлэлийн өндөр технологи, тоног төхөөрөмжүүдийг бүтээн байгуулалтын бүхий л цаг үед нийлүүлж ирсэн Герман улсын GEA, хөрөнгө оруулалтын хамтрагч Хайнекен компани, улаан буудайн шар айрагны төгс илэрхийлэл болсон дэлхийд алдартай Баварийн Калтенберг брэндийн төлөөлөл, Бавари мужийн өв залгамжилсан хунтайж эрхэмсэг ноён Луитпольд Генрих тэргүүтэй хүндэт зочид хүрэлцэн ирсэн юм.

Мөн АПУ ХК-ийн урилгаар Монгол улсын ардын жүжигчин Э.Амартүвшин "Домог" болсон алдарт дуучин Пласидо Доминго тэргүүтэй дэлхийн шилгүүдтэй эх орондоо хослон дуулж, Centennial Celebration" дуурийн сонгодог тоглолтыг зохион байгуулж Сүхбаатарын талбайд шууд дамжуулан хүргэснээр хэрэглэгчид, хамтрагч түншүүддээ бэлэг барилаа.














## ТОП 100 АЖ АХУЙН НЭГЖ

АПУ компани 20 дахь жилдээ дараалан **ТОП 100 аж ахуйн нэгжээр** шалгарч, АПУ Трейдинг ХХК, СББ ХХК, АПУ Дэйри ХХК компаниуд Монгол улсын ТОП 100 аж ахуйн нэгжээр тодорлоо. Уламжлал, инновацыг хослуулсан сүүн бүтээгдэхүүнийг өдөр тутмын хэрэглээнд өргөнөөр нэвтрүүлж, эрүүл хүнсийг хэрэглэгчийн гарт хүргэхийг зорин ажиллаж буй АПУ Дэйри Монгол сүүний үйлдвэр нь 2017 онд бие даасан аж ахуй нэгж болсноос хойш анх удаа ТОП 100 аж ахуй нэгжийн нэгээр шалгарлаа.

## ГААЛИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН АЖ АХУЙН НЭГЖ

АПУ компанид БНХАУ, БНСУ болон МУ-ын Гаалийн Ерөнхий Газрын төлөөллүүд урьдчилсан аудит хийсний үр дүнд албан ёсоор Гаалийн Итгэмжлэгдсэн Аж Ахуйн Нэгжийн сертификат гардуулгаа. Ингэснээр Гааль, Бизнесийн байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд харилцан итгэлцэл үүсэх, гадаад худалдааны үйл ажиллагааг хөнгөвчлөн хурдастах боломжтой болж байна.

## "ХҮНСНИЙ ШИЛДЭГ ҮЙЛДВЭРЛЭГЧ"

"АПУ Дэйри" Монгол сүүний үйлдвэр **"Хүнсний шилдэг үйлдвэрлэгч"** боллоо.
"Хүнсний хувьсгал" үндэсний хөдөлгөөн, "Алтан намар-2024" арга хэмжээний баярын хурлаар Хүнс, хөдөө аж ахуйн салбарын шилдэг 10 үйлдвэрлэгчийг бүс бүрээс шалгаруулж, Төвийн бүсээс шилдэг үйлдвэрлэгчийн нэгээр АПУ ДЭЙРИ-Монгол сүүний үйлдвэр шалгарлаа. АПУ компани нь 2006 оноос эхлэн "Цэвэр сүү" үйлдвэрлэж эхэлсэн ба АПУ Дэйри ХХК нь 2017 оноос бие даан өргөжиж нийт 9 брэндийн 100 гаруй төрлийн сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.

## MONDE SELECTION & WORLD BEER AWARDS

Дэлхийн шилдэг шар айргийг тодруулдаг **Monde Selection & World Beer Awards** шалгаруулалтуудаас СЭНГҮР шар айраг **ХОС АЛТАН МЕДАЛЬ** авч олон улсад амт чанараараа өрсөлдөхүйц гэдгээ баталлаа.

## "МОНГОЛ УЛСЫН ХҮНСНИЙ МАНЛАЙ ҮЙЛДВЭР"

Монголын Хүнсчдийн нэгдсэн холбооноос салбартаа манлайлан ажиллаж, үндэсний үйлдвэрлэлээ бататган хөгжүүлж, эх орноо олон улсад сурталчлах, экспортын зах зээлийн цар хүрээгээ тогтмол өргөжүүлж буй хувь нэмрийг үнэлэн **"МОНГОЛ УЛСЫН ХҮНСНИЙ МАНЛАЙ ҮЙЛДВЭР"**-ээр АПУ компанийг тодруулдаа

## ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ




Бид түүхт 100 жилийн ойн тэмдэглэлт арга хэмжээний үеэр "Монгол Бахархал" Тогтвортой хөгжлийн стратеги 2030-аа дэлхийн томоохон түнш байгууллагууд, харилцагч, ханган нийлүүлэгчдийнхээ өмнө албан ёсоор танилцууллаа.

Эх дэлхий болон Монгол улсдаа ямар хөрөнгө оруулалт, үр нөлөө, үнэ цэнийг бүтээхээ зорилгож бид бүхий л тогтвортой хөгжлийн ажлууд болон зорилтуудыг нэгтгэн системчилж 5 ханат нөлөөллийн гэр моделийн дагуу 2030 он хүртэлх "Монгол Бахархал" Тогтвортой хөгжлийн стратегийн тэргүүлэх чиглэлүүдээ боловсруулж баталсан юм.




### APULSE ZONE – PLAYTIME ХӨГЖМИЙН НААДМЫН СТРАТЕГИЙН ТҮНШЭЭР АЖИЛЛАВ

Байгальд ээлтэй Playtime хөгжмийн наадамд стратегийн түншээр оролцлоо. Бид "Бахархалт Монгол" тогтвортой хөгжлийн стратегийнхаа хүрээнд хүлэмжийн хийн ялгарлаа бууруулах зорилгоор APULSE Zone-оо нарны эрчим хүчээр цэнэглэв.

Нийт 2430кВт цахилгаан эрчим хүч хэрэглэснээс 10% буюу 260.8кВт-ийг нарны системээсээ хангалаа. Энэ нь 26,080ш LED гэрлийг нэгэн зэрэг асаахтай тэнцэх юм. Бид нарны системээ нэг удаагийн арга хэмжээн дээр хэрэглээд зогсохгүй, АПУ ХК-ийн савлах үйлдвэрийн болон гадна талбайн гэрэлтүүлгийг шийдэн ажиллаж байна.


















## АПУ КОМПАНИЙГ БОДИТООР МЭДЭРСЭН "ALWAYS FORWARD TOGETHER EXPERIENCE SHOW"

100 жилийн ойн хүрээнд **"Always forward Together – Experience Show"** цоо шинэ арга хэмжээг зохион байгууллаа.
Бид 100 жилийн хугацаанд олон улсын түвшний өвөрмөц брэндүүдийг бүтээж, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн инновацийг тасралтгүй хийж буй хамт олон, харилцагч, хамтрагч нартаа зориулж брэнд бүтээх үйл явц үйлдвэрлэлийн технологи, хэрэглэгчдэд хүрэх үе шат бүрээ таниулж, биечлэн мэдрэх боломж бүрдүүлэн ирээдүйн зорилгоо хамтдаа хэлэлцсэн юм.

Энэ арга хэмжээ нь хамт олон харилцагчдадаа цоо шинэ мэдрэмжийг төрүүлэхээс гадна түүхий эд татан авалт, брэндийн утга учир, үнэ цэн, түүх, уламжлал, инновац гэх мэт бүхий л шинэлэг туршлага, мэдээллийг нэг дор хүлээн авах боломж олгосноороо ач холбогдолтой.

# ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ




## ХАЙНЕКЕН ШАР АЙРГИЙГ ЭХ ОРОНДОО ҮЙЛДВЭРЛЭЖ ЭХЛЭВ

Дэлхий дахинаа брэнд үнэ цэнээрээ тэргүүлдэг Хайнекен брэндийг АПУ компани цоо шинэхнээр нь үйлдвэрлэн, хэрэглэгчдэдээ хүргэж эхэллээ.

150 жилийн түүхтэй, 190 гаруй улсын хэрэглэгчдэд таашаагдаж буй тус шар айргийг одоогийн байдлаар 71 улс дотооддоо үйлдвэрлэх эрхийг авч, үйл ажиллагаагаа явуулж байгаа юм.

Хайнекен Монголд үйлдвэрлэлийн төсөл 22.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалттайгаар амжилттай хэрэгжиж, 91%-ийн гүйцэтгэлтэй ажиллалаа. Төслийн хүрээнд шинэ исгэлт болон савлах тоног төхөөрөмж суурилуулж, автоматжуулалтын шийдлүүдийг нэвтрүүлэн олон улсын стандартын дагуу савлах болон үйлдвэрлэлийн боломжуудыг нэмэгдүүлэв.

2024 оны 8 сараас эхлэн Хайнекен шар айргийг Монголын зах зээлд лаазтай төрлөөр хэрэглэгчдэдээ хүргэж эхэлсэн.

Хайнекен шар айраг нь олон улсын өндөр технологийг шаарддаг ба чанар, стандартын бүхий баталгаажуулалтын шалгуурыг АПУ ХК давсан нь дэлхийн түвшний үйлдвэрлэгч болохыг гэрчилж буй юм.

Зөвхөн үйлдвэрлэл төдийгүй хүний нөөц, технологи, процесс менежментийн түвшинд олон улсад ийнхүү хүлээн зөвшөөрөгдөж байна.



# The Signing Ceremony of Facility Agreement



## АПУ ХК СҮҮНИЙ САЛБАРТ НОГООН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХЭЭР АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК (АХБ), ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ ХӨГЖЛИЙН БАНК (ЕСБХБ)-ТАЙ $40 САЯЫН САНХҮҮЖИЛТИЙН ГЭРЭЭ БАЙГУУЛЛАА

АПУ ХК нь АПУ Дэйри Монгол сүүний үйлдвэрийн шинэ үйлдвэрийн бүтээн байгуулалтыг уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах тогтвортой, ногоон үйлдвэрийн чиг баримжаа баримталж эрчим хүчний хэмнэлтийн шалгуурт нийцсэн сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр үйл ажиллагаагаа явуулах боломжтой шийдлээр байгуулахаар зорьж АХБ, ЕСБХБ-тай хамтран 50:50 хувиар санхүүжүүлснээр нийт $40 саяын гэрээг АПУ ХК, АПУ Дэйри Монгол сүүний үйлдвэртэй байгуулав. Энэхүү санхүүжилтийн гэрээ нь хүнс, хөдөө аж ахуйн салбарт ногоон үйлдвэрлэл, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах чиглэлээр олон улсын томоохон хөгжлийн санхүүгийн байгууллагуудтай өргөн хүрээнд хамтран хийж буй анхны хамтын ажиллагаа гэдгээрээ онцлогтой юм.

Сүү, сүүн бүтээгдэхүүний салбарт малчид, фермерүүдийн сүү нийлүүлэлтийг өсгөх, малчдын амьжиргааг дэмжих улмаар хүн амын эрүүл мэндэд ээлтэй сүүн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд АПУ Дэйри Монгол сүүний үйлдвэрийн хүчин чадлыг 3 дахин нэмэгдүүлж, өргөтгөх шинэ бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлээд байна.

ADB Solving Complex Challenges Together

European Bank for Reconstruction and Development

## ХАЯГДАЛ УС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР БАЙГУУЛЖ БАЙНА

Үйлдвэрийн хаягдал ус боловсруулах үйлдвэр барих төсөл нь АПУ ХК-ийн үндсэн үйлдвэрүүд, АПУ Дэйри ХХК болон М-Би-Си Азиа Пасифик ХХК-ийн үйлдвэрээс гарч байгаа технологийн хаягдал усыг насос станцад цуглуулан, улмаар цэвэрлэх үйлдвэрт хүргэж, Дахин ашиглах цэвэрлэсэн усны техникийн ерөнхий шаардлага, стандартыг /MNS 6734:2018/ хангасан ус гаргаж авах зорилготой ажиллаж байна.



# 2024 ОНЫ ЭКСПОРТЫН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

**ОХУ- ын зах зээлд**

2024 онд Москва, Тюмень, Хабаровск хотуудад ArtGer-тэй хамтран, монгол уламжлал, идээ ундааны соёл, брэнд бүтээгдэхүүнийг танилцуулсан арга хэмжээнүүдийг харилцагч наргаа зохион байгуулсан нь зочдын сонирхлыг татаж, брэндийн ойлголтыг гүнзгийрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэлээ.

Мөн "Simple Wine" нэртэй ОХУ-ын тэргүүлэгч дарсны сэтгүүл АПУ компани болон шилдэг брэндүүдийн тухай нийтлэл гаргасан нь брэндийн нэр хүндийг улам бэхжүүлсэн үйл явдал боллоо.

АПУ компани ОХУ дахь зах зээлээ идэвхтэй тэлж, Алс Дорнод, Сибирь, Москва болон Санкт-Петербург зэрэг стратегийн бүсүүдэд тогтвортой түншлэлүүдийг амжилттай хөгжүүлсээр байна. TEBIZ GROUP-ийн судалгаагаар ОХУ-ын зах зээлд архи экспортлогч орнуудын дунд Монгол Улс нь тэргүүлэгч 10 орны нэгээр нэрлэгдэж байна.

2024 онд АПУ компанийн ОХУ дахь архины экспортын орлого өмнөх оноос 11 хувиар өсч, компанийн тогтвортой өсөлтийн хандлагыг баталгаалаа.

**БНХАУ-ын зах зээлд**

АПУ компани нь үндэсний үйлдвэрлэл, соёл уламжлалыг дэлхийд сурталчлах эрхэм зорилгынхоо хүрээнд гадаад зах зээлд, тэр дундаа БНХАУ-д амжилттай үйл ажиллагаа явуулж байна. 2024 онд Хятадын томоохон хотууд болох Харбин, Шанхай, Хөх хотод зохион байгуулагдсан олон улсын үзэсгэлэн, соёлын арга хэмжээнд оролцож, экспортын шилдэг брэндүүдээ амжилттай танилцуулжээ. Брэндийн танилцуулгаас гадна Artger-тэй хамтран үндэсний хоол, соёлыг сурталчилсан өдөрлөгүүдийг ч хамтран зохион байгуулсан нь Монгол брэндийн үнэ цэнийг улам нэмэгдүүлсэн байна.

Түүнчлэн, АПУ ХК нь Хятадын цахим худалдааны зах зээлд хөл тавьж, орчин үеийн хэрэглэгчидтэй илүү ойр харилцах зорилгоор социал медиа платформууд дээр албан ёсны хаягуудаа нээсэн нь брэндийн үнэнч хэрэглэгчдийн хүрээг тэлэхэд чухал алхам болсон.

Эдгээр цогц арга хэмжээний үр дүнд 2024 онд АПУ ХК-ийн БНХАУ дахь экспортын борлуулалтын орлого өмнөх онтой харьцуулахад 53%-иар өссөн нь тус компанийн олон улсын зах зээлд өргөжин тэлэх стратеги үр дүнгээ өгч буйг харуулж байна.

















### АНУ/Европын зах зээлд

2024 онд Германы Дюссельдорф хотноо зохион байгуулагддаг дэлхийн хамгийн том шингэн хүнсний Prowein олон улсын үзэсгэлэнд хоёр дахь жилдээ оролцож, Chinggis Khan, Chinggis Grand Khan, Soyombo, Eden брэндүүдийн чанар, түүх утга агуулгыг дэлхийн 65 орны 50,000 гаруй хэрэглэгчдэд хүргэлээ.

Европын тансаг аялал жуулчлалын бүс нутаг болох Швейцарь улсын Гштаад хотод Монголын уламжлалт хүнну гэрийн хэв маягийг шингээсэн Chinggis Khan нэрийн лоунж байршуулж, зочдод өв соёл, брэндийн философийг онцгой туршлагаар дамжуулан хүргэлээ.

Итали Улсын Ром хот дахь Дэлхийн шилдэг 100 рестораны жагсаалтын 33-т жагсдаг Nite Kong лаунжид зохион байгуулсан "Mongolian Nite" арга хэмжээ нь Монголын соёл, урлаг, идээ ундааны соёлыг нэгэн үдшийн хүрээнд Европын үзэгчдэд онцгой мэдрэмжээр хүргэж Chinggis Khan брэндийн олон талт үнэ цэнийг илэрхийлсэн гайхалтай үдэш болж өнгөрөв.

Харин АНУ-н зах зээлд 2022 оноос эхлэн 3 жил дараалан зохион байгуулсан Chinggis Khan Golf Cup тэмцээн нь олон улсын харилцагч, түншүүдтэй харилцаагаа гүнзгийрүүлэх, монголын өв соёл, АПУ компанийн бүтээгдэхүүний чанар, чансааг бататгах чухал арга хэмжээ болж өнгөрөв.

Америкийн Нэгдсэн Улсад 2023 оноос эхлэн Нью-Йорк, Вашингтон, Калифорни, Канзас, Техас, Флорида, Аризона, Невада, Колорадо, Теннесси зэрэг 34 мужуудад хэрэглэгчдийн гарт шууд хүргэх www.chinggiskhan.com цахим платформыг эхлүүлсэн. Ийнхүү жилийн чанадад АПУ компанийн сор болсон бүтээгдэхүүн болох дээд зэрэглэлийн "Чингис Хаан" брэндийг дэлхийн хэрэглэгчдэд хүргэсээр байна.

### БНСУ-ын зах зээлд




2022 оноос эхлэн БНСУ-ын GS25 дэлгүүрүүдээр "Алтанговь" шар айраг албан ёсоор худалдаалагдаж эхэлсэн бөгөөд хэрэглэгчид маань зөвхөн дэлгүүрээр зогсохгүй, GS25-ийн онлайн дэлгүүр болон Shinsagae-ийн татваргүй барааны цахим худалдааны сувгаар ч худалдан авах боломжтой болсон. Энэ нь бидний хэрэглэгчдэдээ улам ойртуулах чухал алхам болсон юм.



2024 оноос бид Солонгос дахь үйл ажиллагаагаа өргөжүүлэн, "Эден" брэндийн архийг зөвхөн GS25 дэлгүүрүүдээр бус, мөн төрөл бүрийн ресторан, баруудтай хамтран нийлүүлж эхлээд байна.




Үүнтэй зэрэгцэн, бид Монголын соёл, өв уламжлалыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор Солонгост зохион байгуулагддаг олон улсын үзэсгэлэн, арга хэмжээнд тогтмол оролцож ирсэн. Тухайлбал, "Seoul Bar & Spirit Show" болон "GS25 Beer & Music Festival" арга хэмжээнүүдэд амжилттай оролцож, Монголын байгаль, соёл, уламжлалыг олон мянган хэрэглэгч, бизнесийн төлөөлөлд таниулсан юм. Эдгээр арга хэмжээнд нийт давхардсан тоогоор 100,000 гаруй хүн оролцсон байна.

2024 онд хэрэгжүүлсэн бидний хүчин чармайлт нь АПУ компанийн "Үндэсний бахархлыг дэлхийд хүргэх" алсын харааг бодитоор хэрэгжүүлж буй үйл явдал болж байна.

# БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ

2024 онд бид шинэ бүтээгдэхүүний туршилт судалгааг тасралтгүй хийж, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлага, хүсэл сонирхолд нийцсэн, эрүүл мэндэд тустай, хэрэглэхэд хялбар байх шийдлийг хангасан хэмжээ, сав баглаа боодол, орц найрлага бүхий шинэ амт, технологи өнгө төрх бүхий брэндүүдийг хөгжүүлэн ажиллалаа.




Инновац-Шинэчлэл

16




8

Онцгой савлагаа




Шинэ төрөлжилт

50




7

Шинэ трэнд

# 2024 ОНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ




## ШАР АЙРГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Монгол улсын шар айргийн зах зээл 2024 онд биет хэмжээгээр 7.3% өсөж 131 сая литрт хүрч сүүлийн 10 жилийн хамгийн өндөр түвшинд хүрээд байна. 2024 оны байдлаар нийт 8 брэндийн бүтээгдэхүүнийг гадаад, дотоодын зах зээлд үйлдвэрлэн нийлүүлж байна.




## АРХИН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛ

2024 оны байдлаар биет хэмжээгээр 30 сая литрт хүрч өнгөрсөн жилээс 6.1 хувиар өссөн байна. АПУ ХК нь 2024 оны байдлаар нийт 19 брэндийн бүтээгдэхүүнийг дотоод, гадаадын зах зээлд үйлдвэрлэн нийлүүлээд байна.




## ДАРСНЫ ЗАХ ЗЭЭЛ

Манай улсын дарсны зах зээл 2024 оны байдлаар биет хэмжээгээр 3 сая литрт хүрч өнгөрсөн жилээс 6.8 хувиар буураад байна. АПУ ХК нь 2023 оны байдлаар нийт 19 брэндийн бүтээгдэхүүнийг импортлон дотоодын зах зээлд нийлүүлээд байна.




## ИМПОРТЫН ВИСКИ БОЛОН БУСАД ЗАХ ЗЭЭЛ

2024 онд Монголд импортоор орж ирж байгаа виски болон бусад бор спиртэн бүтээгдэхүүний нийт зах зээл 1.29 сая литрт хүрсэн байна. 2024 оны байдлаар АПУ компани нь нийт 17 брэндийн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлж байна.

## УС, УНДАА ШҮҮСНИЙ ЗАХ ЗЭЭЛ

2024 оны байдлаар Монгол улсын ус ундааны зах зээл биет хэмжээгээр 534 сая литрт хүрч өнгөрсөн жилээс 15 хувиар өссөн байна. АПУ ХК нь 2024 оны байдлаар нийт 6 брэндийн бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлд үйлдвэрлэн нийлүүлж байна.



# ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ



Цэвээнжавын
**ЭРДЭНЭБИЛЭГ**
*Гүйцэтгэх захирал*



Дандарова
**АРИУНА**
*Экспорт эрхэлсэн захирал*



Батсайханы
**ЦАЦРАЛ**
*Борлуулалт, маркетинг эрхэлсэн захирал*



Жаргалсайханы
**ИЧИНХОРЛОО**
*Захиргаа, Хүний нөөц эрхэлсэн захирал*



Добрев
**НИКОЛАЙ**
*Үйлдвэрлэл, үйл ажиллагаа эрхэлсэн захирал*



Заховал
**АЛЕШ**
*Үйлдвэрлэл, үйл ажиллагаа эрхэлсэн захирал*



Гончигийн
**ЭНХБИЛЭГ**
*Санхүү эрхэлсэн захирал, Төслийн удирдлагын захирал*



Галсумъягийн
**БАЯРМАГНАЙ**
*АПУ Дэйри ХХК-ийн Гүйцэтгэх захирал*

# АПУ ГРУПП КОМПАНИЙН БҮТЭЦ

APU COMPANY
Absolute. Pure. Unique.

- СББТ
- Grand
- APU TRADING
- Чингисхаан Интернэшнл Лиметэд
- СББ
- ГРАНД ИСТ
- APU DAIRY
- 爱啤酉
- MBC ASIA PACIFIC

Хараат компани

- DIGITAL CONCEPT

2024 онд АПУ Групп компанийн бүтцэд өөрчлөлт ороогүй.





# ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

## СЭЛБЭГ ҮЙЛДВЭРЛЭЛД 3D ПРИНТЕРИЙГ НЭВТРҮҮЛЛЭЭ

АПУ компани нь засвар үйлчилгээний системийг үе шаттайгаар шинэчилж, сэлбэгийн хадгалалт, зохион байгуулалт болон сэлбэгийн менежментийг сайжруулан нэвтрүүлж байна. Үүний хүрээнд сэлбэг үйлдвэрлэлд 3D принтерийн технологийг амжилттай нэвтрүүлж, тоног төхөөрөмжийн яаралтай шаардлагатай сэлбэгүүд, үйл ажиллагааг хөнгөвчлөх, онцлог эд ангиудыг дотооддоо үйлдвэрлэх боломжтой боллоо.

Мөн үйлдвэрлэлийн хэсэгт тоног төхөөрөмжийн ажиллагааг сайжруулах, шинэчлэх, хялбаршуулах зорилгоор үндсэн эд анги, багаж хэрэгслийн загвар зохион бүтээж, турших нөхцөл бүрдээд байна.

3D принтерийг ашигласнаар:

- Сэлбэгийн нийлүүлэгчээс хамаарах байдал буурч,
- Сэлбэг хүлээн авах хугацаа багассанаар үйлдвэрлэлийн тасалдал багасч,
- Засвар үйлчилгээний зардал буурч байгаа зэрэг олон давуу талууд бий болж байна.







## ЧАНАР БОЛОН ISO МЕНЕЖМЕНТ

АПУ ХК-ийн бүх компаниуд ISO 9001:2015 болон FSSC 22000 стандартын дагуу SGS байгууллагын олон улсын аудитад амжилттай хамрагдаж, баталгаажуулалтаа үргэлжлүүллээ.

**Бүтээгдэхүүний чанар, шинэлэг байдлыг сайжруулах судалгаа**

2024 онд бүтээгдэхүүний савлагаа, шинэлэг байдлыг сайжруулах зорилгоор олон улсын стандартад нийцсэн чанарын аудитыг борлуулалтын багтай хамтран өргөн хүрээтэй зохион байгуулахаар ажиллаж байна.

**FSSC 22000 v6 шинэчлэлтийг нэвтрүүлэв.**

Шинэчилсэн стандартын хүрээнд эрүүл ахуй, хог хаягдлын менежмент, онцгой байдлын бэлэн байдал зэрэг олон чиглэлд ажил хийж, ажилтнуудын хүнсний аюулгүй байдлын соёлын түвшин 89.7% хүрч, олон улсын хэмжээнд өндөр үнэлгээ авлаа.





## БҮТЭЭМЖИЙН УДИРДЛАГА

Азийн бүтээмжийн байгууллагын "Жижиг дунд үйлдвэрлэлийн салбарын бүтээмжийн өгөөжийн хуваарилалт" сэдэвт олон улсын арга хэмжээг Улаанбаатар хотод зохион байгуулсан ба энэхүү арга хэмжээний хүрээнд Азийн 18 улсын төлөөлөгчид АПУ компанийн Бүтээмж, чанарыг дээшлүүлэх арга хэрэгслүүдийг нэвтрүүлэн ажиллаж байгаа туршлагатай танилцлаа.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Азийн бүтээмжийн байгууллага, Монголын бүтээмжийн төв хамтран бүтээмжийн үзэл баримтлалыг тодорхойлж, үндэсний хэмжээнд бүтээмжийн мастер төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэхэд талуудыг оролцоог хангах зорилгоор 2024 оны 12 дугаар сарын 17-ний өдөр "БҮТЭЭМЖИЙН ХУВЬСГАЛ" зөвлөлдөх уулзалтанд АПУ компани "Бүтээмж, чанарын хөтөлбөрүүд" сэдвээр хүрээнд компанидаа хэрэгжүүлж буй туршлага үйл ажиллагаагаа хуваалцсан юм.

Мөн Хайнекен HUB support процессыг амжилттай эхлүүлсэн ба 2024.06.01 – 2024.12.01 хооронд TPM HUB Веатнамын багаас АПУ Төв үйлдвэрлэлийн хэсэгт хандны алдагдал болон хөргөлтийн хэсгийн цахилгааны хэрэглээг бууруулах сайн туршлагуудыг амжилттай хэрэгжүүллээ.

## WH МЕНЕЖМЕНТ - GPS ХЯНАЛТЫН СИСТЕМ ХЭРЭЖҮҮЛЭЛТ

2024 онд Агуулах хоорондын тээврийн үйл ажиллагаанд тээврийн хэрэгслийн байршлын GPS хяналт болон түлшний хяналтыг системийг бүрэн нэвтрүүллээ. Тээврийн хэрэгслийн зорчилт, хөдөлгөөнийг зайнаас хянаснаар үйл ажиллагааны хяналт, тээврийн хэрэгслийн төлөвлөгт, зохион байгуулалт, цаг ашиглалт, гүйцэтгэл мэдэгдэхүйц сайжирсан юм. Мөн тээврийн хэрэгслийн зорчилт, зогсолтын хяналтын тайланг системээс гаргах боломжтой болсноор түлшний норм тогтоолтыг бодитой болгох, нормын хяналтыг нарийн хянах боломжтой болов.





АПУ ХК-ийн Бүтээмжийн удирдлага болон Агуулах, ложистикийн төлөөлөл 2024 оны 9 сард Индонез улсын Жакарта хотод зохион байгуулагдсан "Харилцагчийн үйлчилгээ, ложистик" чиглэлийн бүтээмжийг сайжруулах воркшопт амжилттай оролцоод ирлээ. Нийт Хайнекен компанийн Ази, Номхон далайн бүс нутгийн 11 орны төлөөлөл оролцсон энэхүү сургалт, воркшоп нь Ложистикийн хэсэгт бүтээмжийн өсөлтийг авчрах шинэ мэдлэг, туршлагаар арвин байсны хажуугаар Индонез улсын үйлдвэрүүдийн бүтээмжийн системийн туршлагатай танилцаж, бүс нутгийн мэргэжилтнүүдийн хамтын ажиллагааг бэхжүүлэхэд асар их хувь нэмэр оруулсан юм.



## МОНГОЛ БАРТЕНДЕР ДЭЛХИЙД ӨРСӨЛДӨВ

Шар айргийн амт, чанар, үнэ цэнээрээ дэлхийд дээгүүрт тооцогддог Хайнекен брэндийн зүгээс 2013 оноос хойш Олон улсын бартендеруудын дунд "Heineken Global Draught Champions" буюу Задгай шар айргийг төгс аягалж, үйлчлэх дэлхийн аварга бартендерийг шалгаруулах тэмцээнийг жил бүр зохион байгуулдаг ба цар тахлын улмаас дөрвөн жил завсарлаад энэ жилээс дахин үргэлжлүүлэн зохион байгуулж эхэллээ.




Уг тэмцээн нь "Heineken" компанийн өлгий нутаг Нидерланд улсын Амстердам хотноо 2024 оны 12 сарын эхний 7 хоногт амжилттай зохион байгуулагдаж Монгол, Швед, Хорват, Энэтхэг зэрэг дэлхийн өнцөг булан бүрээс 20 гаруй орны шилдэг бартендерууд уг тэмцээнд өрсөлдөж аваргаа тодруулсан.

Улс бүрийн шилдгүүдтэй Монгол улсаа төлөөлөн "976 Ulaanbaatar" рестораны бартендер Наранбилэгт өрсөлдөн гайхалтай аягалалтаараа хагас финалд шалгаран 5-р байр эзэллээ.






## НИЙТ АЖИЛТНЫ ТОО:

**2402**

## ХҮЙСИЙН ХАРЬЦАА:




## АЖИЛЛАСАН ЖИЛ:



# ТЭГШ ХҮРТЭЭМЖТЭЙ АЖЛЫН БАЙР

Хүний нөөцийн сонгон шалгаруулалт, компанийн брэндинг, процессуудыг дижиталжуулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тэгш, хүртээмжтэй ажлын байрны боломжийг бий болгох зорилгоор олон ажлыг гүйцэтгэлээ.

✓ Ажиллах хүч, өрсөлдөгч байгууллага, хөдөлмөрийн зах зээлийн (захын жишээн дээр) судалгааг хийж, үр дүнг нэгтгэн ажиллав.

✓ Hello.apu.mn хүний нөөцийн вэб нь ажлын байрны зар, онлайн анкет бөглөх, хүний нөөцийн захиалгыг автоматжуулах боломжийг олгож, цаасан процессуудыг халж, ашигт ажиллагааг нэмэгдүүлсэн.

✓Компанитай танилцах аялалуудыг зохион байгуулж, хүний нөөцийн бодлого, идэвхжүүлэлтийн хөтөлбөрүүдийг оюутан залууст танилцуулан хэрэгтэй мэдээллээр хангаж байна.

✓ Цагийн ажилтны системийг хөгжүүлэн цагийн ажил сонирхсон иргэдийг бүртгэн авч, шаардлагатай үед хүссэн цагийн ажлаа хийх боломжийг бүрдүүлж байна.

✓ "Career up" хөтөлбөрөөр ажилчдыг сургаж, дэвших боломж олгож, давхар ажиллах хөтөлбөрөөр хүүхэд асрах чөлөөтэй эсвэл ажлын цагийн дараа нэмэлт орлого олох ажлуудыг зарлалаа.

**ХҮРТЭЭМЖТЭЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ХҮРЭЭНД:**

✓Хүртээмжтэй ажиллах орчин болон тохирох ажлын байрыг бий болгох зорилгоор REHTUS компанитай хамтран АПУ компанийн нийт ажлын байрны хүртээмжийн үнэлгээний тайлан хийлээ.

✓Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвүүдтэй харилцаа холбоог сайжруулж үйлдвэртэй танилцах аялал хийж, ажиллах орчин компанийн мэдээллээр хангаж, нээлттэй ажлын байрны мэдээллээр хангасаар байна.

✓Нийт ХБИ 10 ажилтан ажлын байрны тохируулга хийж, ажлын байрыг бэлдэн REHTUS компанитай хамтран ажлыг эхлүүлэн явж байна.

✓ХБИ-ийн хөдөлмөрийг дэмжих хүрээнд бусад иргэний нийгмийн байгууллагатай уулзаж хамтарч ажиллах талаар байнгын судалгаа хийж байна.






## ХҮНИЙ НӨӨЦИЙН УРАМШУУЛАЛ ХӨНГӨЛӨЛТИЙН ЦОГЦ СИСТЕМ БҮХИЙ "NOVA EMPLOYEE LOYALTY" ХӨТӨЛБӨР

АПУ компани ур чадварт суурилсан хамт олон байх алхмуудыг шат дараалан хийж, хүний нөөцийн инновацлаг орчин үеийн дижитал хөтөлбөрүүдийг ийнхүү санаачлан ажилласаар байна.

**Nova гэж юу вэ?**

Nova нь компанийн нийт ажилтнууд гар утсаар болон WEB-ээр дамжин ашиглах боломжтой ажилтны бүх төрлийн урамшуулал, хөнгөлөлт хангамж зэргийг багтаасан нэгдсэн систем юм.

Цаасан байдлаар бус цахимаар шийдэх, хүн төвт бодлого, хүчирхэгжсэн хамт олон хэсгийн хүрээнд ажилтан бүрийн нийгмийн хэрэгцээ, тогтмол урамшуулал, сургалт хөгжил, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээ гэх мэт цогц хүний нөөцийн урамшуулал хөнгөлөлтийн үйл ажиллагааг багтаасан цахим платформ бүхий "NOVA EMPLOYEE LOYALTY" хөтөлбөрийг хөгжүүлж, нэвтрүүлэн ажиллаж байна.







## БИДНИЙ ХАМТЫН АЯЛАЛ: ИННОВАЦИЛАГ ХӨНГӨЛӨЛТ УРАМШУУЛАЛ

**BOOSTI BE**

АПУ компани нийт ажилчдынхаа ая тухтай ажиллах орчин, нөхцөлийг бүрдүүлэн, хүн төвтэй засаглалыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүний хүрээнд ажилтнуудынхаа суралцаж хөгжих эрмэлзэл, хоорондын ялгаатай хэрэгцээ шаардлага, эрүүл амьдралын хэв маягийг бий болгох, гэр бүл, хувийн амьдралдаа анхаарал хандуулах, цаг зарцуулах зэрэг хүсэл хэрэгцээнд тулгуурлан өөрт хэрэгцээт урамшууллыг ажилтан өөрөө сонгох боломжийг олгосон BOOSTIBE урамшууллын инновацлаг хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлээд байна.

**BOOSTI PAY**

Цагийн ажилтны хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж, түүнтэй холбоотой үүссэн цалин хангамжийг өдөр бүр шилжүүлэх системийг хөгжүүлэн ажиллаж 470 минутын ажлыг 115 минут болгон бууруулж шууд онлайн шилжүүлэг хийдэг боллоо. Ингэснээр цагийн ажилтнууд ажлын хөлсөө өдөр бүр эсвэл долоо хоног бүр авах боломжтой болсон. Энэхүү системийг хөгжүүлснээр хүний нөөцийн бүрдүүлэлтийг дэмжих, богино хугацаанд ажиллах хүч нэмэх, ажлын урсгалыг оновчтой болгож байна.




# АЖЛЫН ШИНЭ ЭРИН

powered by ESSA

## ESSA

Бизнесийн үйл ажиллагааны үйл явцыг хялбарчлах, автоматжуулах төслийн хүрээнд нийт 81 процесс сайжруулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

## RPA – Технологи дэвшил

Цаг хугацаа их зарцуулдаг, олон дахин давтагддаг ажлуудаа Роботоор хийлгэж гар ажиллагааг багасгасан, цаг хугацааг хэмнэн технологийн дэвшлийг ашиглаж байна. Энэ онд бид:

- ELIMINATE - 42%
- STANDARTIZE - 5%
- SIMPLIFY - 12%
- AUTOMATE - 41%

# СУРГАЛТ ХӨГЖИЛ




### Коучинг хөтөлбөр

АПУ компанийн хэмжээнд коучинг ур чадварыг удирдлага, менежерүүдийн эзэмшсэн байх чухал ур чадвар хэмээн үзэж 2023 онд PWC -тэй хамтран Мэргэжлийн Коуч бэлтгэх 9 сарын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж нийт 28 коуч бэлтгэсэн билээ.

2024 онд эдгээр мэргэжлийн Коуч нартайгаа хамтран АПУ компанийн хэмжээнд Коучингийн соёлыг хөгжүүлэх үүднээс "Коучинг 2024" хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлсэн бөгөөд цахимаар уулзалтын цагаа товлон Коучээ сонгон уулзалт хийх боломжийг нийт ажилтнуудаа олгож байна. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь хувь хүний болон мэргэжлийн тогтвортой хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэх, шийдвэрээ өөрөө гарган гүйцэтгэлээ хамгийн дээд хэмжээнд хүргэхэд нь туслах замаар тасралтгүй суралцаж хөгжих эрмэлзэлтэй соёлыг бий болгон бүтээмжийг нэмэгдүүлэх юм



### Удирдлагын манлайллын төсөл

Байгууллагын соёл ба чадавхи нь удирдлагуудын хүнээ удирдах арга барилаас үүдэлтэй бөгөөд энэ нь бизнесийн өрсөлдөх давуу талыг бий болгох суурь юм. АПУ компанийн манлайлах арга барилын онцлогийг илрүүлэх, ур чадвар болон зан төлвийн үзүүлэлт болгон хөрвүүлэх, нийт 3 түвшний удирдлагуудад манлайллын зан төлвийн хүлээлтээ ойлгуулж цаашид нэгдмэл хүчтэй АПУ соёлыг төлөвшүүлэх нь энэхүү төслийн зорилго юм.

Төслийн үр дүнд манлайллын ур чадварыг удирдагуудын бүх түвшинд тодорхойлон гаргав. Тодорхойлсон ур чадваруудыг нийт удирдлагуудад таниулах 21 удаагийн воркшопыг зохион байгуулав.

# APU Lead



## 360 Манлайллын Үнэлгээ

### Удирдах ажилтны 360 үнэлгээг эхлүүлэв

Удирдлагын манлайллын ур чадварын матрицийг тодорхойлон бий болгосонтой холбоотой бүх шатны удирдлагуудаас 360 үнэлгээг авахаар төлөвлөж үнэлгээний системийг боловсруулан бий болгов. Зорилго нь компанийн удирдлагын манлайллын ур чадварын шаардлагыг ажилтнуудын одоогийн түвшинтэй харьцуулах замаар сургалтын хэрэгцээг тодорхойлох зорилготой юм.




### 50 ажилтанд байрны урьдчилгааны дэмжлэг үзүүллээ

АПУ компанийн Хөнгөлөлт, тусламж олгох тухай журам болон Захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хооронд байгуулсан хамтын гэрээний дагуу баг хамт олныхоо хүндлэлийг хүлээн, компанидаа үнэ цэнийг бүтээж, идэвх санаачилгатай ажилласан нийт 50 ажилтанд байрны урьдчилгааны дэмжлэг үзүүлсэн.


03

# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Компанийн ерөнхий мэдээлэл
Хувьцаа эзэмшигчид
Төлөөлөн удирдах зөвлөл
Хувьцааны мэдээлэл
Ногдол ашгийн мэдээлэл
Бизнесийн ёс зүй
Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт



# КОМПАНИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Оносон нэр:
**АПУ**

Хэлбэр:
**Нээлттэй хувьцаат компани**

Регистрийн дугаар:
**2702673**

Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллага:
**Монголын хөрөнгийн бирж**

МХБ-ийн хувьцааны бүртгэлийн ангилал:
**I**

Гаргасан нийт хувьцааны тоо ширхэг:
**1,064,181,553**

Бизнесийн үндсэн үйл ажиллагааны салбар:

- **Архины үйлдвэрлэл**
- **Шар айрагны үйлдвэрлэл**
- **Спиртийн үйлдвэрлэл**
- **Ундаа, ус, жүүсний үйлдвэрлэл**
- **Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл**

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

**Хувьцаа эзэмшигчдийн тоо[1]**




**Хувьцаа эзэмшигчдийн тоогоор тэргүүлэгч топ-5 хувьцаат компани**




Өнгөрөгч онтой харьцуулбал хувьцаа эзэмшигчийн тоо **55%**-аар өссөн бөгөөд хувьцаат компаниуд дунд дөрөвдүгээрт эрэмбэлэгдэж байна.

[1] [illegible]

### Хувьцаа эзэмшигчдийн бүтэц[2]




### Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид

| | Хувьцаа эзэмшигч | 2023 оны эцэс | | 2024 оны эцэс | |
|---|---|---|---|---|---|
| | | Хувьцааны тоо ширхэг | Нийт гаргасан хувьцаанд эзлэх хувь | Хувьцааны тоо ширхэг | Нийт гаргасан хувьцаанд эзлэх хувь |
| 1 | Шунхлай Холдинг ХХК | 598,230,342 | 56.22 | 602,651,260 | 56.63 |
| 2 | Heineken Asia Pacific Pte Ltd | 266,091,981 | 25.00 | 266,091,981 | 25.00 |
| 3 | Steppe Beverage KFT | 112,264,896 | 10.55 | 59,351,609 | 5.58 |
| 4 | Бусад | 87,808,918 | 8.25 | 136,086,703 | 12.79 |

Өмнөх онтой харьцуулбал нөлөө бүхий хувьцаа эзэмшигч Шунхлай холдинг ХХК-ийн эзэмшлийн хувьцаа 4,420,910 ширхэг буюу 0.42%-аар нэмэгдсэн бол Степпе Бэвэрик КФТ-ийн эзэмшлийн хувьцаа 52,913,287 ширхэг буюу 4.97%-аар буурч олон нийтийн эзэмшилд шилжиж.

### Хувьцаа эзэмшигчдийн хурал

АПУ ХК-ийн эрх барих дээд удирдлага нь хувьцаа эзэмшигчдийн хурал юм.
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал цахим хэлбэрээр 2024 оны 04 сарын 30-ны өдрийн 14:00 – 15:30 цагийн хооронд 88.08%-ийн ирцтэй хуралдаж, дараах шийдвэрүүдийг гаргав:

1. АПУ ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан "АПУ групп компани 2023 онд тавьсан зорилтуудаа биелүүлж, амжилттай ажилласан" гэсэн дүгнэлтийг батлав.
2. АПУ ХК-ийн ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгов.
3. АПУ ХК-ийн ТУЗ-ийг дараах бүрэлдэхүүнтэйгээр 3 жилийн хугацаагаар сонгов:

Ердийн гишүүн

1. Пүрэвийн Батсайхан
2. Бүрэнтогтохын Батбаяр
3. Кеннет Чу
4. Сэн И-Ин
5. Батсайханы Гантиг
6. Баярцогтын Гомбо-Эрдэнэ

Хараат бус гишүүн

1. Ёндон-Ойдовын Гэрэлчулуун
2. Одончимэдийн Одбаяр
3. Жигжидийн Үнэнбат

4. АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллыг ТУЗ-ийн дарга 10 сая, ТУЗ-ийн гишүүд 6.5 сая байхаар батлав.

[2] ҮЦТХТ ХХК-аас гаргасан 2024.12.31-ний өдрийн байдлаарх үнэт цаас эзэмшигчдийн судалгааны мэдээлэл

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт ТУЗ компанийг удирддаг.
ТУЗ нь Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, Компанийн дотоод дүрэм журамд заасан АПУ ХК-ийн ТУЗ-ийн болон түүний охин, хараат компаниудын хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх, үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлдэг.

## ТУЗ-ийн бүрэлдэхүүн



ПҮРЭВИЙН **БАТСАЙХАН**
*ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд ТУЗ-ийн дарга*



БҮРЭНТОГТОХЫН **БАТБАЯР**
*ТУЗ-ийн ердийн гишүүн*



**КЕННЕТ ЧУ**
*ТУЗ-ийн ердийн гишүүн*



**СЭН И-ИН**
*ТУЗ-ийн ердийн гишүүн*



БАТСАЙХАНЫ **ГАНТИГ**
*ТУЗ-ийн ердийн гишүүн*



БАЯРЦОГТЫН **ГОМБО-ЭРДЭНЭ**
*ТУЗ-ийн ердийн гишүүн*



ЖИГЖИДИЙН **ҮНЭНБАТ**
*ТУЗ-ийн хараат бус гишүүн*



ЁНДОН-ОЙДОВЫН **ГЭРЭЛЧУЛУУН**
*ТУЗ-ийн хараат бус гишүүн*



Одончимэдийн **ОДБАЯР**
*ТУЗ-ийн хараат бус гишүүн*



**СЕРГЕЙ ГРОМОВ**
*ТУЗ-ийн ердийн гишүүн*



ДОРЖИЙН **МИЕЭГОМБО**
*ТУЗ-ийн ердийн гишүүн*

Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хурлаар ТУЗ-ийн бүрэн эрхийг дуусгавар болгож, шинэ бүрэлдэхүүнийг 3 жилийн хугацаатай сонгосноор доорх өөрчлөлт орсон:
- ТУЗ-ийн гишүүн Сергей Громов, Доржийн Миеэгомбо нарын оронд Б.Гантиг, Б.Гомбо-Эрдэнэ нар шинээр сонгогдов.

## ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан

ТУЗ нь танхимаар, танхим-цахим хосолсон, эчнээ санал хураалтын хэлбэрээр нийт 13 удаа, дунджаар 99%-ийн ирцтэй хуралдаж, бүрэн эрхийнхээ хүрээнд нийт 58 тогтоол гаргав.

| Д/д | Огноо | Ирц | Нийт | АПУ ХК | АПУ Дэйри ХХК | АПУ Трейдинг ХХК | М Би Си Азиа Пасифик ХХК | СББ Трейд ХХК | Спирт бал бурам ХХК | ОХУ-ын Трэйд ХХК | ОХУ-ын Трэйд Ист ХХК | БНХАУ ӨМӨЗО-ны Эйпиюу трейд ХХК |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Баталсан тогтоолын тоо | | | | | | | | | |
| | | | | ТУЗ-ийн хурал | Хувьцаа эзэмшигчдийн хурал | | | | | | | |
| 1 | 2024.02.16 | 100% | 13 | 3 | 3 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 |
| 2 | 2024.03.20 | 100% | 2 | 1 | 1 | | | | | | | |
| 3 | 2024.04.15 | 100% | 13 | 5 | 2 | 1 | 3 | 1 | 1 | | | |
| 4 | 2024.05.10 | 89% | 3 | 2 | | | | | 1 | | | |
| 5 | 2024.06.24 | 100% | 1 | | | | 1 | | | | | |
| 6 | 2024.07.08 | 100% | 1 | 1 | | | | | | | | |
| 7 | 2024.07.23 | 100% | 2 | 2 | | | | | | | | |
| 8 | 2024.08.01 | 100% | 6 | 4 | 2 | | | | | | | |
| 9 | 2024.09.04 | 100% | 1 | 1 | | | | | | | | |
| 10 | 2024.10.23 | 100% | 5 | 1 | | 1 | 1 | 1 | 1 | | | |
| 11 | 2024.11.29 | 100% | 2 | 2 | | | | | | | | |
| 12 | 2024.12.10 | 100% | 8 | 1 | | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 |
| 13 | 2024.12.25 | 100% | 1 | 1 | | | | | | | | |
| | **Нийт** | **99%** | **58** | **24** | **8** | **4** | **7** | **4** | **5** | **2** | **2** | **2** |

Жилийн турш ТУЗ-ийн гишүүн бүрийн хуралд оролцсон ирц:



### ТУЗ-ийн дэргэдэх хороод

Компанийн тухай хуулийн 81.2-т заасны дагуу ТУЗ-ийн дэргэд Аудитын, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хороо ажилладаг бөгөөд хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүн юм.
Тайлант хугацаанд ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй ба хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хурлаар ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг шинээр сонгосны дараа 2024 оны 05 сарын 10-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар хороодын бүрэлдэхүүнийг улираан томилсон.
ТУЗ-ийн дэргэдэх хороод Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, хороодын журамд заасан эрх, үүргийг хэрэгжүүлэн ажиллав.

## АУДИТЫН ХОРОО

| Бүрэлдэхүүн | ТУЗ-ийн гишүүний хэлбэр | Нэрс |
|---|---|---|
| Хорооны дарга | Хараат бус гишүүн | Ж.Үнэнбат |
| Гишүүд | Ердийн гишүүн | Сэн И-Ин |
| | Хараат бус гишүүн | О.Одбаяр |

| | |
|---|---|
| Хуралдсан тоо | 3 |
| Хуралдсан ирц | 100% |
| Хэлэлцэн шийдвэрлэсэн асуудал | 1. Групп компанийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын байгууллагын дүгнэлттэй танилцах<br>2. Дотоод аудитын 2023 оны ажлын тайлан, 2024 оны ажлын төлөвлөгөөтэй танилцах<br>3. Групп компанийн хэмжээнд 2024 оны санхүүгийн тайланг шалган баталгаажуулах аудитын байгууллагыг сонгох, аудитын ажлын хөлсний хэмжээг ТУЗ-д санал болгох |

## ДОТООД АУДИТ

### Дотоод аудитын бодлого

Дотоод аудит нь Компанийн үйл ажиллагааг үнэлэх, сайжруулах, түүний үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хараат бус, бие даасан, бодитойгоор баталгаа өгөх зөвлөх үйл ажиллагаа юм.
Дотоод аудитын нэгж нь Компанийн бүхий л түвшинд эрсдэлд суурилсан дотоод аудитыг дараах чиглэлээр явуулдаг. Үүнд:

- Компанийн засаглалын үйл явцыг үнэлж, сайжруулах зөвлөмж өгөх;
- Эрсдэлийн удирдлагын үйл явцын үр нөлөөтэй ба үр ашигтай байдлыг үнэлэх сайжруулах;
- Дотоод хяналтын системийн үр нөлөөтэй ба үр ашигтай байдалд үнэлгээ хийх, баталгаа гаргах;
- Компанийн санхүүгийн үйл ажиллагаа нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн, мөрдөж буй заавар, журмын дагуу үнэн зөв тайлагнаж буй эсэхэд баталгаажуулалт өгөх;
- Монгол улсын хэмжээнд мөрдөгдөж буй хууль, дүрэм, журам, бизнесийн болон бусад мэргэжлийн ёс зүйн дүрэм, олон улсын болон дотоодын стандарт шаардлага, нормын мөрдөлт тэдгээрийн хэрэгжилтэд баталгаажуулалт хийх;
- Компанийн хөрөнгө хамгаалалт болон хөрөнгийн зүй зохистой ашиглалтад баталгаажуулалт хийх, залилан мэхлэлт, шамшигдуулалт, хувийн ашиг сонирхлын шинжтэй аливаа үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх зөвлөмжөөр хангах

Дотоод аудитыг гүйцэтгэхэд аудиторууд компанийн бизнесийн ёс зүйн дүрэм болон Дотоод Аудиторын Олон Улсын Институтээс гаргасан ёс зүйн дүрэм, мэргэжлийн ёс зүйг баримтлахаас гадна дараах зарчмыг баримтална. Үүнд:

- шударга байх,
- бодитой байх,
- Хараат бус, бие даасан байдлыг хангах
- нууц хадгалах,
- мэргэжлийн мэдлэг, ур чадвартай байх.

### Дотоод аудитын бүтэц




Дотоод аудитын бүтэцэд өөрчлөлт гараагүй.

## ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

### Эрсдэлийн удирдлагын бодлого

Эрсдэлийн удирдлагын бодлогоор "эрсдэл" гэдэгт компани зорилго, зорилтдоо хүрэхэд учрах тодорхой бус байдал, үр дагавар, гарз хохирлыг ойлгохоор заасан. Компанийн эрсдэлийн удирдлагын үйл явц нь эрсдэлийг тодорхойлж бүртгэх, эрсдэлийг үнэлэх, эрсдэлийг удирдах гэсэн үндсэн гурван үе шатыг хамарна. Эрсдэлийг эх үүсвэрээс нь хамааруулан гадаад, дотоод эрсдэл, үр дагавраас хамааруулан стратегийн, санхүүгийн, үйл ажиллагааны, комплайнсын, бусад эрсдэл хэмээн ангилдаг.

Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

- Соёлыг түгээх,
- Үнэ цэнийг бүтээх,
- Шийдвэр гаргалтад ашиглагдах,
- Мэдээлэлтэй, ил тод байх,
- Тасралтгүй байх.

### Эрсдэлийн удирдлага

АПУ ХК нь тогтвортой хөгжлийн тулгуур багана болох байгаль орчин, нийгэм, эдийн засагт ээлтэй засаглалыг бэхжүүлэхэд онцгой анхааран ажиллаж байна. Ялангуяа аливаа хийгдэж буй төсөл хөтөлбөр, томоохон хөрөнгө оруулалтын шийдвэрүүдээ тогтвортой хөгжлийн зарчим, чиг хандлагад нийцүүлэн шийдсээр байна. Тухайлбал: Нүүдэлчин малчдыг сүү, сүүн бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээнд нэгтгэх, сүү боловсруулах хүчин чадлыг нэмэгдүүлэх, тогтвортой мал аж ахуйн менежментийг дэмжих зорилгоор 20 сая ам.доллартой тэнцэх төгрөгийн санхүүжилтийг Азийн Хөгжлийн Банкнаас татаж чадлаа. Энэхүү хамтын ажиллагаа нь Монгол Улсад сүү, сүүн бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээг илүү уян хатан, хүртээмжтэй болгоход чиглэсэн чухал алхам юм. Орон нутгийн сүүний үйлдвэрлэлийг дэмжиж, малчдад уур амьсгал, эдийн засгийн сорилтод дасан зохицоход нь туслах замаар улс орны хүнсний аюулгүй байдлыг нэмэгдүүлж, 300 малчныг мал аж ахуй, бэлчээрийн тогтвортой менежментэд сургах, санхүүгийн боловсрол олгох, тэдний жендерийн тэгш байдал болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх мэдлэгийг дээшлүүлж, уур амьсгалын тэсвэрлэх чадварыг нэмэгдүүлээд зогсохгүй 1000 малчны амьжиргааг дээшлүүлж, эмэгтэйчүүдийг ажлын байраар хангаж, сүү, сүүн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээнд хамрагдах боломжийг олгох үнэ цэнтэй ажлыг эхлүүлж байна. Цаашлаад малын тэжээлийн үйлдвэр байгуулах, үйлдвэрийн хаягдал ус цэвэрлэх байгууламжийг барих төслүүдийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Ингэснээр эрсдэлийн удирдлагыг илүү өргөн хүрээнд авч хэрэгжүүлэх боломжтойн зэрэгцээ аливаа болзошгүй эрсдэл, тодорхойгүй нөхцөл байдлыг урт хугацаандаа оновчтой удирдахад туслах юм.

Мөн манай салбарын болон компанийн үйл ажиллагаанд шууд болон шууд бус байдлаар нөлөөлөх томоохон эрсдэлүүдийг бид тооцоолж тодорхойлсон ба эдгээрээс хамгийн өндөр ач холбогдолтой гэдгээр нь голлох 5 эрсдэлийг онцоллоо. Үүнд геополитикийн нөлөөлөл, тогтворгүй байдал, хууль эрх зүйн орчны өөрчлөлтүүд, байгаль цаг уурын гэнэтийн өөрчлөлт, давагдашгүй хүчин зүйл, эдийн засгийн орчны нөлөөлөл, болон хэрэглээний шилжилт, хэв маягтай холбоотой нөлөөллийг хамруулав. Эдгээрээс урьдчилан сэргийлэх, хамгийн бага эрсдэлийн түвшинд оновчтой удирдахын тулд шаардлагатай хариу арга хэмжээнүүдийг тодорхойлж нэгдсэн удирдлага зохион байгуулалтын дагуу шат шатандаа анхааран ажилласаар байна. Нэн ялангуяа урт болон богино хугацааны санхүүг төлөвлөх, процессыг сайжруулахад чиглэсэн санал санаачилгуудыг дэмжих зорилтын хүрээнд дотооддоо олон төрлийн төсөл, хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлж, мөн үйлдвэрлэл үйл ажиллагааны тасалдалгүй байдлыг хангах, хөрөнгө оруулагч, ажилтан, хэрэглэгч нийлүүлэгчид болох компанийн бүхий л оролцогч талуудын сэтгэл ханамжийг дээшлүүлж үнэ цэнийг түгээхэд төвлөрлөө.

Үүний зэрэгцээ дотоод эх үүсвэртэй эрсдэлүүдээ ARM буюу эрсдэлийн удирдлагын программаар дамжуулан тодорхойлж, үнэлэн, дүн шинжилгээ хийж байна. Улмаар бусад алба нэгжүүдийн оролцоотойгоор зохимжит түвшинд эрсдэлийг бууруулах, хариу арга хэмжээний төлөвлөгөө болон ажлын гүйцэтгэлд нь мөшгөлт хийж учирч болох эрсдэлийг удирдан ажиллаж байна.

# ГАДААД ХҮЧИН ЗҮЙЛСИЙН НӨЛӨӨЛӨЛ БА ТОМООХОН ЭРСДЭЛҮҮД

## ГАДААД ОРЧНЫ ЭРСДЭЛ

2024

- ▲ (улаан) ТОМООХОН ӨӨРЧЛӨЛТ
- ▲ (ногоон) ШИНЭЭР ҮҮССЭН
- ● (шар) ӨӨРЧЛӨЛТГҮЙ

### ЭРСДЭЛҮҮД

**1. ГЕОПОЛИТИКИЙН ТОДОРХОЙГҮЙ БАЙДАЛ, АНУ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ БОДЛОГУУД** ▲
- [illegible] болон нийлүүлэлтийн гинжин хэлхээний тасалдлууд ●
- Түүхий эд материалын үнийн өсөлт ●

**2. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ӨӨРЧЛӨЛТ** ●
- Бүх төрлийн согтууруулах ундаа болон [illegible] агуулсан ундаа, [illegible] ОАТ-ын хэмжээ ● ▲
- Шошгоны [illegible], [illegible] өөрчлөлт ▲
- Зар сурталчилгааны [illegible], [illegible] албан татварын [illegible] ▲

**3. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛ** ▲
- Инфляцийн өсөлт ▲
- Валютын ханшийн өөрчлөлт ▲

**4. БАЙГАЛЬ ОРЧНЫ ЭРСДЭЛ** ▲
- ЛА НИНЬО цаг уурын үзэгдэл ▲
- Эрс тэс уур амьсгалын өөрчлөлт, ХАА-н [illegible] ▲

**5. НИЙГМИЙН ОРЧНЫ ЭРСДЭЛ** ▲
- $CO_2$ ялгаруулалт, хуванцрын [illegible], дахин боловсруулалт ▲

### БОЛОМЖУУД

**1. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, МУ-ЫН ЗЭЭЛИЙН ЗЭРЭГЛЭЛ В2** ▲

**2. ЗАСГИЙН ГАЗРЫН ДЭМЖЛЭГ: ОРГАНИК БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТ** ▲

**3. ТЕХНОЛОГИЙН ӨСӨЛТ: ВЬЕТНАМ УЛСТАЙ КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЧИГЛЭЛД ХАРИЛЦААГАА ӨРГӨЖҮҮЛЭВ** ▲

## НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО

| Бүрэлдэхүүн | ТУЗ-ийн гишүүний хэлбэр | Нэрс |
|---|---|---|
| Хорооны дарга | Хараат бус гишүүн | О.Одбаяр |
| Гишүүд | Ердийн гишүүн | П.Батсайхан |
| | Хараат бус гишүүн | Ё.Гэрэлчулуун |
| Хуралдсан тоо | 1 | |
| Хуралдсан ирц | 100% | |
| Хэлэлцэн шийдвэрлэсэн асуудал | 1. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нэр дэвшүүлэх | |

### Залгамж халааны бодлого

Залгамж халааны бодлого нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх, сонгох, залгамж халаа бэлтгэх, сургаж хөгжүүлэх, гүйцэтгэлийг үнэлэх харилцааг зохицуулах бөгөөд тус бодлого нь Нэр дэвшүүлэх хорооноос ТУЗ-ийн гишүүний албан тушаалд тохирох этгээдийг олж тодорхойлох хэлбэр, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчид тавигдах шалгуур, шаардлага, сонгон шалгаруулалтын зарчим, нэр дэвшигчдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхэд мөрдөх журам хийгээд ТУЗ-ийн гишүүний сургалт, хөгжил, гүйцэтгэлийн үнэлгээ зэрэг асуудлыг хамарна.

## ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРОО

| Бүрэлдэхүүн | ТУЗ-ийн гишүүний хэлбэр | Нэрс |
|---|---|---|
| Хорооны дарга | Хараат бус гишүүн | Ё.Гэрэлчулуун |
| Гишүүд | Ердийн гишүүн | Кеннет Чу |
| | Хараат бус гишүүн | Ж.Үнэнбат |
| Хуралдсан тоо | 1 | |
| Хуралдсан ирц | 100% | |
| Хэлэлцэн шийдвэрлэсэн асуудал | 1. ТУЗ-ийн дарга, гишүүний цалин урамшууллыг өмнөх оны дүнгээр өөрчлөлтгүй тогтоох | |

### Цалин урамшууллын бодлого

Цалин урамшууллын бодлого нь Компанийн хэмжээнд баримтлах цалин хөлс, урамшууллын зарчмыг тодорхойлж, ТУЗ, Гүйцэтгэх удирдлага, Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд, нийт ажилтнуудын цалин хөлс, урамшууллын тогтолцооны үндсийг тогтооход чиглэгдэнэ.

Компани нь өөрийн цалин урамшууллын тогтолцоонд дараах суурь зарчмыг баримтална. Үүнд:

- Principle of External Equity: Зах зээлд өрсөлдөхүйц цалин урамшууллын тогтолцоогоор дамжуулан мэргэшсэн, өндөр ур чадвартай ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах;
- Principle of Internal Equity: Ижил үнэлэмж бүхий хөдөлмөрт адил цалин, урамшуулал олгох, гүйцэтгэлийн үнэлгээнд суурилсан цалин урамшууллын хуваарилалт аливаа ялгаварлал, гадуурхал тэгш бус байдлаас ангид байх;
- Principle of Individual Worth: Цалин урамшууллыг ажилтны мэдлэг, ур чадвар болон ажлын байрны үнэлгээ, үнэ цэнд суурилж тогтоох.

## ТУЗ-ИЙН ЦАЛИН, УРАМШУУЛАЛ

Цалин урамшууллын бодлогод ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн баталж, гүйцэтгэлийг Компанийн жилийн тайланд тодорхой тусгахаар заасан.
ТУЗ-ийн дарга болон гишүүдэд сар бүр тогтмол цалин олгодог ба нэмэлт урамшуулал олгодоггүй. 2024 онд ТУЗ-ийн цалин, урамшууллын хэмжээнд өөрчлөлт ороогүй.

ТУЗ-ийн гишүүдэд 2024 онд олгосон цалин, урамшууллын хэмжээ

| № | ТУЗ-ийн гишүүн | Сарын үндсэн цалин (төг) | Олговол зохих нийт цалин (төг) | Суутгалын дүн (НДШ, ХХОАТ) | Гарт олгосон нийт цалин |
|---|---|---|---|---|---|
| 1 | П.Батсайхан | 10,000,000 | 120,000,000 | 18,712,200 | 101,287,800 |
| 2 | Б.Батбаяр | 6,500,000 | 78,000,000 | 14,512,200 | 63,487,800 |
| 3 | Кеннет Чу | 6,500,000 | 78,000,000 | 23,190,000 | 54,810,000 |
| 4 | Сэн И-Ин | 6,500,000 | 78,000,000 | 23,190,000 | 54,810,000 |
| 5 | Сергей Громов | 6,500,000 | 26,000,000 | 5,244,200 | 20,755,800 |
| | Б.Гантиг | 6,500,000 | 49,214,266 | 9,926,521 | 39,287,764 |
| 6 | Д.Миеэгомбо | 6,500,000 | 26,000,000 | 5,244,200 | 20,755,800 |
| | Б.Гомбо-Эрдэнэ | 6,500,000 | 49,214,266 | 9,926,521 | 39,287,764 |
| 7 | Е.Гэрэлчулуун | 6,500,000 | 78,000,000 | 13,324,200 | 64,675,800 |
| 8 | Ж.Үнэнбат | 6,500,000 | 78,000,000 | 14,512,200 | 63,487,800 |
| 9 | О.Одбаяр | 6,500,000 | 78,000,000 | 14,512,200 | 63,487,800 |
| | **НИЙТ** | **75,000,000** | **738,428,571** | **155,306,733** | **583,121,839** |

Компанийн засаглалын кодекс (цаашид "Кодекс" гэх)-ийн шаардлагын дагуу 2022 оноос хойш ТУЗ-ийн цалингийн мэдээллийг нээлттэй, ил тод танилцуулж байна.

## ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ЦАЛИН, УРАМШУУЛАЛ

Цалин урамшууллын бодлогод Гүйцэтгэх захирлын цалин, урамшуулал үндсэн цалин, урамшууллаас бүрдэж, ТУЗ-тэй байгуулсан гэрээгээр тодорхойлогдохоор заасан.
Компанийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал (хувь хүн) хэрэгжүүлдэг. Гүйцэтгэх захирлыг сонгох, чөлөөлөх, бүрэн эрхийг тогтоох, түүнтэй байгуулах гэрээний нөхцөл, цалин, шагнал урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох нь ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарна.
АПУ ХК-ийн Гүйцэтгэх захирал нь Компанийн охин компаниуд болох АПУ Трейдинг ХХК, М Би Си Азиа Пасифик ХХК, СББ Трейд ХХК, Спирт бал бурам ХХК, ӨМӨЗО-ны
Эйпиюу Трейд ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар давхар томилогдон ажилладаг.
Гүйцэтгэх захиралд ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан үндсэн цалингаас гадна "борлуулалтын орлого", "хүү, татварын өмнөх ашиг", "зардлын хэмнэлт", "хүн ба байгууллагын хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэл болон байгууллагын соёлыг сайжруулах ажлуудын үр дүн" гэсэн гүйцэтгэлийн 4 үндсэн шалгуур үзүүлэлтийг жил хувийн жинтэйгээр тооцож, урамшуулал олгодог.

## АЖИЛТНЫ ЦАЛИН, УРАМШУУЛАЛ

Цалин урамшууллын бодлогод Компанийн гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд болон нийт ажилтны цалин, урамшууллыг Гүйцэтгэх захирал тогтоохоор заасан.

### ТУЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН ҮНЭЛГЭЭ

СЗХ-ноос 2024 онд ТУЗ-ийн үйл ажиллагааг үнэлэх гарын авлагыг боловсруулан гаргасан бөгөөд энэхүү аргачлалд үндэслэн ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооноос ТУЗ-ийн үйл ажиллагааг үнэлэх, ТУЗ-ийн гишүүн бүрийг үнэлэх үнэлгээг анх удаа зохион байгуулж, үр дүнг нэгтгэн танилцуулж байна.

**ТУЗ-ийн үнэлгээний дүн**




**ТУЗ-ийн гишүүдийн үнэлгээний дүн**



## ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

ТУЗ-ийн хурлын 2024 оны 09 сарын 04-ний өдрийн тогтоолоор ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Чадраабалын Ариунсангийн оронд Базаррагчаагийн Сарантунгалагийг томилсон.

| ТУЗ-ийн нарийн бичгийн дарга | |
|---|---|
| 2024 оны 09 сарын 04-ний өдрөөс өмнө | 2024 оны 09 сарын 04-ний өдрөөс хойш |
| *ТУЗ-ийн нарийн бичгийн дарга*<br>Чадраабалын **АРИУНСАН**<br>*ОУ худалдаа, Бизнесийн удирдлага мэргэжилтэй*<br>*2012-2024 онд АПУ ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга*<br>*Хувьцаа эзэмшил: 1,400 ширхэг (0.00%)*<br> | *ТУЗ-ийн нарийн бичгийн дарга*<br>Базаррагчаагийн **САРАНТУНГАЛАГ**<br>*Бизнесийн удирдлага мэргэжилтэй*<br>*2024 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга*<br>*Хувьцаа эзэмшил: 2,405 ширхэг (0.00%)*<br> |

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-өөс 2023 оны 01 сарын 24-ний өдөр баталсан "ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үйл ажиллагааны журам"-ыг мөрдлөг болгон ажилладаг ба 2024 онд Компанийн ТУЗ-ийн ажлын албаны дарга бөгөөд Комплайнсын нэгжийн удирдлагын үүргийг гүйцэтгэж ажиллав.

## ТУЗ-ИЙН АЖЛЫН АЛБА

АПУ ХК-ийн ТУЗ-ийн ажлын алба нь ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, комплайнсын мэргэжилтэн, хуулийн зөвлөх, үнэт цаасны мэргэжилтэн, нягтлан бодогч гэсэн орон тооны бүтэцтэйгээр АПУ ХК болон Дэйри ХХК-ийн ТУЗ-ийн ажлын албаны үүргийг давхар хариуцан ажилладаг.

| Компанийн эрх барих этгээд | Хуралдсан тоо |
|---|---|
| АПУ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал | 1 |
| АПУ ХК-ийн ТУЗ-ийн болон охин компаниудын хувьцаа эзэмшигчдийн хурал | 13 |
| АПУ ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын хурал | 5 |
| АПУ Дэйри ХХК-ийн ТУЗ-ийн хурал | 7 |
| Нийт | 26 |

Компанийн засаглалтай холбоотой асуудлуудыг шууд хариуцан, үнэт цаас гаргагчийн тогтмол биелүүлэх үүргийн хэрэгжилтийг хангах үндсэн чиг үүрэг бүхий тус алба нь 2024 онд дараах хурлуудыг зохион байгуулж, ТУЗ болон хороодын ажиллах нөхцөлийг хангаж ажиллав. Үүнд

Мөн онд хоёр удаа ногдол ашиг зуучлуулан тараалгах гэрээг ҮЦТХТ ХХК-тай байгуулж, ногдол ашиг төлөхтэй холбоотой харилцааг хариуцан ажиллав.

| Тайлант хугацаа | ТУЗ-өөс ногдол ашиг зарласан өдөр | Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг | Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гарах бүртгэлийн өдөр | Ногдол ашиг төлөхөөр тогтоосон сүүлийн өдөр | Ногдол ашгийг ҮЦТХТ ХХК-аар зуучлуулан төлсөн/төлөх өдөр |
|---|---|---|---|---|---|
| 2024 оны I хагас жил | 2024.08.01 | 55 төг | 2024.08.20 | 2025.02.10 | 2024.10.02 |
| 2024 оны II хагас жил | 2025.02.10 | 65 төг | 2025.04.04 | 2025.08.19 | 2025.04.30 |
| **НИЙТ** | | **120 төг** | | | |

## КОМПЛАЙНСЫН НЭГЖ

Комплайнсын нэгжийн үйл ажиллагаанд ТУЗ-өөс 2023 оны 12 сарын 05-ны өдөр баталсан "Комплайнсын хяналтын заавар", 2023 оны 02 сарын 13-ны өдөр баталсан "Бизнесийн ёс зүйн дүрэм" багц бодлогын "Мөнгө угаахтай тэмцэх, хориг арга хэмжээний бодлого" болон 2024 оны 11 сарын 29-ний өдөр шинээр баталсан "Хориг арга хэмжээний журам"-ыг тус тус баримтлан ажиллав.

### Хориг арга хэмжээнээс сэргийлэх

Бид аливаа худал, хууль бус үйлдлийг шууд болон шууд бусаар санхүүжүүлэхгүй байх зарчмыг баримталдаг бөгөөд 2023 оноос эхлэн Олон улсын LexisNexis системийн тусламжтай Компанитай гэрээлэгч хуулийн этгээд, хувь хүнийг шүүн шалгаж, хориг арга хэмжээнд орсон талтай аливаа бизнесийн холбоо тогтоохоос сэргийлэн ажилладаг.

LexisNexis
RISK SOLUTIONS

### Шүгэл үлээх

2024 онд бизнесийн ёс зүйн зөрчил болон аливаа зүй бус үйлдлийн талаар мэдээллийг хүлээн авах, нэрээ нууцалж мэдээлэл гаргах, гаргасан мэдээллийнхээ шийдвэрлэлтийн явцыг хянах боломжтой "Шүгэл үлээх систем"-ийг ашиглалтад оруууллаа. Уг системээр ирсэн мэдээллийг Комплайнсын нэгж хүлээн авч, ёс зүйн хороонд шилжүүлэн шийдвэрлүүлж, ТУЗ-д тайлагнадаг. 2024 онд системээр 5 мэдээлэл хүлээн авч, 100% шийдвэрлэсэн байна.






# ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

## ХУВЬЦААНЫ ИДЭВХ

Өнгөрөгч 2024 оны байдлаар хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаагаар нийт 317.52 тэрбум төгрөгийн хувьцаа арилжаалагдсан байна. АПУ ХК-ийн хувьцааны арилжаа нийт арилжааны 3.9 хувийг эзэлж, үнийн дүнгийн эрэмбээр идэвхтэй арилжаалагдсан топ 10 хувьцааны зургаадугаарт жагссан бол зах зээлийн үнэлгээгээр дөрөвдүгээрт жагсжээ.

**ИДЭВХТЭЙ АРИЛЖААЛАГДСАН ТОП 10 ХУВЬЦАА, 2024 ОН**
*ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР*




**ХАМГИЙН ӨНДӨР ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭТЭЙ 10 КОМПАНИ, 2024 ОН**
*ИХ НАЯД ТӨГРӨГӨӨР*




АПУ ХК-ийн хувьцаа оны сүүлээр хамгийн идэвхтэй арилжаалагдсан бөгөөд зөвхөн 12 сард нийт жилийн хувьцааны арилжааны дүнгийн 24.6 хувь нь хийгдсэн байна.

**НИЙТ ХУВЬЦААНЫ АРИЛЖААЛАГДСАН ДҮН, 2024 ОН**
*ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР*




**НИЙТ АРИЛЖААЛАГДСАН ХУВЬЦААНЫ ТОО ШИРХЭГ, 2024 ОН**
*САЯ ШИРХЭГЭЭР*



## ХУВЬЦААНЫ ҮЗҮҮЛЭЛТ

**ХУВЬЦААНЫ ХААЛТЫН ХАНШИЙН ХӨДӨЛГӨӨН, 2024 ОН**
*төгрөгөөр*




EPS

| 2023 | 2024 |
|---|---|
| ₮110.0 | ₮181.3 |

P/B

| 2023 | 2024 |
|---|---|
| 1.57 | 1.34 |

P/E

| 2023 | 2024 |
|---|---|
| 9.10 | 5.52 |

НИЙТ ХУВЬЦААНЫ АРИЛЖААЛАГДСАН ДҮН

| 2023 | 2024 |
|---|---|
| ₮16.18 тэрбум | ₮12.58 тэрбум |

**Earning per share** (нэгж хувьцаанд ногдох ашиг) нь 2024 оны байдлаар 181.3 төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 71.3 төгрөгөөр нэмэгджээ. EPS 181.3 гэдэг нь тухайн компани нэг хувьцаанд 181.3 төгрөгийн ашиг олж буйг илтгэнэ. Уг үзүүлэлт нэмэгдэхэд цэвэр ашиг 64.8 хувиар өссөн гол нөлөөг үзүүлэв.

**Price to book** ( үнэ дансны үнийн харьцаа) нь 2024 оны байдлаар 1.34 байгаа буюу 2023 онтой харьцуулахад 0.23 нэгжээр буурсан ба уг бууралтад компанийн өөрийн хөрөнгө 16.8 хувиар өссөн нь гол нөлөөг үзүүлэв.

**Price to earnings** (үнэ ашгийн харьцаа) нь 2024 онд 8.89 болсон бөгөөд өмнөх оны мөн үеэс 3.58 нэгжээр багасаж 5.52 болсон бөгөөд энэ нь компанийн цэвэр ашгийн өсөлттэй шууд хамааралтай юм.

**Нийт хувьцааны арилжаалагдсан дүн.** "АПУ" ХК нь Монголын хөрөнгийн биржийн топ-20 индекст багтдаг нэр хүндтэй нөлөөтэй компаниудын нэг билээ. 2024 онд тус компанийн хувьцааны нийт 12.58 тэрбум төгрөгийн арилжаа явагджээ.

# НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

## НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

Ногдол ашгийн бодлого нь хувьцаа эзэмшигчдэд хуваарилах ногдол ашгийн хэмжээг тодорхойлох, түүнийг хуваарилах тухай шийдвэр гаргах, энэ талаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, ногдол ашгийг төлөх, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулна.

Компани нь хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай удирдаж, нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээг тогтвортой байлгах зарчим баримталдаг.

Компани доор дурдсан нөхцөлд цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилна. Үүнд:

- Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх,
- Ногдол ашиг төлсний дараа Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, түүний татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс их байх,
- Компани эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх.

Ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэрийг ТУЗ гаргах ба санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор, хагас жилээр ногдол ашиг хуваарилах тохиолдолд хагас жилийн санхүүгийн тайлан гарснаас хойш 30 хоногийн дотор хэлэлцэн шийдвэрлэнэ.

ТУЗ нь ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэвэл энэ тухайгаа хувьцаа эзэмшигчдийн хуралд заавал тайлагнана.

## НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАЛТ

АПУ ХК нь 2005 оноос хойш 692.2 тэрбум төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдээ хуваарилжээ. Ногдол ашгийг 2020 оноос хойш жил бүр хоёр удаа тогтмол тарааж байна.

**НЭГЖ ХУВЬЦААНД ЗАРЛАСАН НОГДОЛ АШГИЙН ХЭМЖЭЭ БОЛОН ӨГӨӨЖ**
*ТӨГРӨГӨӨР, ХУВИАР*




*Тайлбар: Өгөөж = нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг/хаалтын ханш*

Компанийн хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцаанд 2024 оны нийлбэр дүнгээр нийт 120 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн болно.

Ногдол ашгийн төлбөрийг нийт хувьцааны тавaас доош хувийг эзэмшигчдэд "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-аар зуучлуулан, тавaас дээш хувийг эзэмшигчдэд компаниас шууд төлөх замаар мөнгөн хэлбэрээр олгож байна.

# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ

СЗХ-ноос баталсан "Компанийн засаглалын кодекс"-ийг хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд компанийн засаглалын бодлого, дүрэм журам, зааврыг үе шаттайгаар шинээр болон шинэчлэн батлахаар төлөвлөснөөс 2024 онд дараах баримт бичгийг боловсруулж, ТУЗ-өөс баталсан байна. Үүнд:

| Д/д | Баримт бичгийн нэр | Хэрэгжилт | Баталсан огноо, тайлбар |
|---|---|---|---|
| 1 | Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах журам | Шинэчлэн баталсан | ТУЗ-ийн 2024 оны 02 сарын 16-ны өдрийн 24/03 тоот тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулж, хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байх заалтыг нэмсэн. |
| 2 | Тогтвортой хөгжлийн стратеги | Шинээр баталсан | ТУЗ-ийн 2024 оны 07 сарын 23-ны өдрийн 24/13 тоот тогтоолоор АПУ Групп компанийн 2030 он хүртэл баримтлах тогтвортой хөгжлийн стратегийг баталсан (дэлгэрэнгүйг тогтвортой хөгжил хэсгээс үзнэ үү). |
| 3 | Хориг арга хэмжээний журам | Шинээр баталсан | ТУЗ-ийн 2024 оны 11 сарын 29-ний өдрийн 24/22 тоот тогтоолоор батлагдсан энэхүү журмаар АПУ Групп компанийн үйл ажиллагаанд хориг арга хэмжээтэй холбогдуулан дагаж мөрдөх журмыг тогтоож, хоригийг зөрчихөөс урьдчилан сэргийлэх, шалгалт хийх, хяналт тавих, сургалт зохион байгуулах, тайлан гаргахтай холбоотой харилцааг зохицуулна. |
| 4 | Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам | Шинээр батлах | Боловсруулж дууссан. ТУЗ-өөр батлуулахаар хүлээгдэж байна. |

### КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын 2022.06.09-ний өдрийн А/58 тушаалаар баталсан аргачлалын дагуу АПУ ХК-аас Кодексийн хэрэгжилтийн өөрийн үнэлгээг 2024 оны эцэст нэг удаа хийсэн ба СЗХ-ны Компанийн засаглал, комплайнсын хэлтсээс хянан баталгаажуулсан үр дүнг доор үзүүлэв.

АПУ ХК-ИЙН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХЯНАН БАТАЛГААЖИЛТ

| | | | 2024 оны I хагас жил | | 2024 оны эцэс | |
|---|---|---|---|---|---|---|
| Д/д | Гарчиг | Авбал зохих нийт оноо | Үнэлсэн оноо | Үнэлгээний хувь | Үнэлсэн оноо | Үнэлгээний хувь |
| 1 | ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт | 12 | 7 | 58% | 10 | 83% |
| 2 | ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг | 10 | 10 | 100% | 10 | 100% |
| 3 | Тайлагнал, мэдээллийн ил тод байдал | 6 | 6 | 100% | 6 | 100% |
| 4 | Аудит, хяналтын тогтолцоо | 6 | 6 | 100% | 6 | 100% |
| 5 | Эрсдэлийн удирдлага | 8 | 8 | 100% | 8 | 100% |
| 6 | Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал | 6 | 5 | 83% | 6 | 100% |
| 7 | Оролцогч талуудын эрх ашиг | 8 | 8 | 100% | 8 | 100% |
| 8 | Компанийн соёл | 6 | 5 | 83% | 5 | 83% |
| 9 | Хувьцаа эзэмшигчдийн эрх | 10 | 9 | 90% | 9 | 90% |
| | Нэгтгэсэн дүн | **72** | **64** | **89%** | **68** | **94.4%** |
| | **Үнэлгээний тайлбар** | | **2. Дунд засаглалтай** | | **1. Засаглал хэвийн буюу эрсдэлгүй** | |
| | **Эрэмбэ** | | 17-р байр | | **4-р байр** | |

АПУ ХК кодексийн хэрэгжилтийн үнэлгээгээр Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй нээлттэй хувьцаат компаниудаас 2024 оны жилийн эцсийн байдлаар 94.4%-ын үнэлгээгээр дөрөвдүгээр байранд эрэмбэлэгдлээ.


04

# ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Ямагт орших өв соёл
Ногоон ба цэвэр тунгалаг
Хүчирхэгжсэн хамт олон
Баялаг, Хариуцлагатай
Тогтвортой түнш



2024 онд АПУ ХК-ийн "Бахархалт Монгол" Тогтвортой хөгжлийн стратеги 2030 нь Төлөөлөн Удирдах Зөвлөлөөр батлагдаж, хэрэгжилтийн суурь үе шат албан ёсоор эхэлсэн. Энэхүү стратеги нь компанийн тогтвортой хөгжлийн зорилтуудыг таван чиглэлд системчилж, бизнесийн шийдвэр, хөрөнгө оруулалт болон өдөр тутмын үйл ажиллагаандаа уялдуулан хэрэгжүүлэх замыг тодорхойлсон байна.

## 2024 ОНД БИД СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮДИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:

- Стратегийн хэрэгжилтийг чиглүүлэх гол үйл ажиллагаанууд болон тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлсон;
- Нөлөөллийн чиглэл тус бүрд төлөөлөх ахлын хүрээг гаргаж, гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг боловсруулах эхлэл тавьсан;
- Хүлэмжийн хийн ялгарлын (Хамрах хүрээ 1, 2, 3) тооцооллыг анх удаа гүйцэтгэн, үндэсний зорилтот хувь нэмэрт (ҮЗХН) оруулах бодит суурийг бүрдүүлсэн;
- Оролцогч талуудын оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх боломжуудыг судалж, дотоод үйл ажиллагаандаа нэгтгэх бэлтгэл ажлуудыг эхлүүлсэн.

Ийнхүү "Бахархалт Монгол" стратеги нь зөвхөн алсын хараа бус, байгууллагын тогтвортой хөгжлийг хэмжих, үнэлэх, ахиц дэвшлийг чиглүүлэх бодит хэрэгжүүлэлтийн хүрээнд шилжиж байгааг онцлон тэмдэглэх байна.

## ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗАСАГЛАЛ

"Бахархалт Монгол" Тогтвортой хөгжлийн стратегийг хэрэгжүүлэх хүрээнд стратегийн таван нөлөөллийн чиглэл тус бүрийг гүйцэтгэх удирдлагуудын хариуцлагын хүрээнд нэгтгэж, байгууллагын түвшний хэрэгжилтийн тогтолцоог бүрдүүлэх эхлэлийг тавилаа. Ингэснээр стратегийн зорилтууд компанийн өдөр тутмын үйл ажиллагаа, удирдлагын шийдвэр гаргалттай шууд уялдаа холбоотой болж байна.






# ЯМАГТ ОРШИХ ӨВ СОЁЛ

## ТОДОРХОЙЛСОН ЗОРИЛГО:

Монгол үндэстний гайхамшигт өв соёлыг ямагт амьд байлгаж, хойч үедээ өвлүүлэн үлдээхэд АПУ ХК өөрийн бизнесийн практик, хамтын ажиллагаа, нөөц боломжоо бүрэн ашиглах болно.

Бид үндэсний үйлдвэрлэлээ дэмжиж, бэлтгэн нийлүүлэгчидтэйгээ тогтвортой хамтран ажиллах зорилтын хүрээнд дараах ажлуудыг амжилттай хэрэгжүүллээ.

## НОГООН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

АПУ компани Азийн Хөгжлийн Банк болон Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банктай хамтран 40 сая амдолларын санхүүжилтийн гэрээ байгууллаа.
Энэхүү хөрөнгө оруулалтаар АПУ Дэйри Монгол сүүний үйлдвэрийн шинэ бүтээн байгуулалтыг ногоон, эрчим хүч хэмнэлттэй, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрт тулгуурлан хэрэгжүүлж байна. Энэ нь олон улсын хөгжлийн санхүүгийн байгууллагуудтай хүнс, хөдөө аж ахуйн салбарт хийж буй анхны томоохон хамтын ажиллагаа юм.

## СҮҮНИЙ САЛБАРТ ХАМТЫН ХӨГЖИЛ

- Үйлдвэрийн хүчин чадлыг 3 дахин нэмэгдүүлэх шинэ бүтээн байгуулалт эхэлсэн.
- 138 сая төгрөгийн түүхий эдийг Архангай аймгийн Чулуут сумаас худалдан авч, орон нутгийн эдийн засгийг дэмжсэн.
- Фермерийн өдөрлөг-өөр сүүний чанар, стандарт, сайн туршлагын талаар сургалт зохион байгуулж, малчдыг чадавхжуулав.
- Малчдад чиглэсэн санхүү, тэжээлийн эко систем бий болгохын тулд APU Дэйри ХХК, GSB Капитал, Мост Финтек, Хөх Үүр Агро хамтран зээлийн апп боловсруулав.
- Өвөлжилт хүндэрсэн бүс нутгийн 400 гаруй малчинд өвс, тэжээлийн тусламж үзүүлсэн.

## "ЭРҮҮЛ МАЛЧИН" ХӨТӨЛБӨР

НЬЮ ЮНИ ХХК-тай хамтран Улаанбаатар болон Сэлэнгэ аймагт 323 малчдад эрүүл мэндийн үзлэг, зөвлөгөө, сургалт зохион байгууллаа. Малчдын хоол, усны хэрэглээ, амьдралын хэв маягт суурилсан эрүүл мэндийн оношилгоо хийж, зөвлөмж өглөө.

### ТОДОРХОЙЛСОН ЗОРИЛГО:

Эх дэлхий, байгаль орчинд үлдээж буй ул мөрөө багасгахын тулд сэтгэлгээний хэвшмэл хязгаарыг давж, сэтгэл зүтгэл гарган, өвөг дээдсийнхээ хадгалан үлдээсэн байгаль экологийн тэнцвэрийг идэвхтэй хамгаална.

### ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРЛЫН ТООЦООЛОЛ

Монгол Улс 2030 он гэхэд хүлэмжийн хийн ялгаралаа 22.7%-иар бууруулах Үндэсний зорилт тавин ажиллаж байна. АПУ ХК энэхүү зорилгод хувь нэмрээ оруулах үүднээс групп хэмжээндээ анх удаа Хүлэмжийн хийн ялгарлын (ХХЯ) тооцооллыг олон улсын аргачлалд тулгуурлан, хамрах хүрээ 1, 2, 3-ын дагуу хийж гүйцэтгэлээ.

### НИЙТ ЯЛГАРЛЫН ХЭМЖЭЭ

Нийт (Хамрах хүрээ 1, 2, 3):

**404,693.39 тн $CO_2e$**

Биогеник ялгарлын хэмжээ:

**1,167.35 тн $CO_2e$**

Тооцооллыг GHG Protocol болон ISO 14064-1 стандартын дагуу, олон улсын аргачлал ашиглан гүйцэтгэж, гуравдагч байгууллагаар баталгаажуулан, ISO 14064-1 сертификат авлаа. Энэхүү тооцоолол нь цаашдын бууруулах арга хэмжээг төлөвлөх, хариуцлагатай үйл ажиллагаар хэрэгжүүлэх суурь болж байна.

### ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

"Дахин боловсруулцгаая – Go Recycle" аяны ивээн тэтгэгч

АПУ ХК 2024 оноос эхлэн "Өнгө нэм" НҮТББ-ын хэрэгжүүлж буй "Go Recycle" олон нийтийн боловсролын хөтөлбөрийн ерөнхий ивээн тэтгэгчээр ажиллаж байна. Аяны зорилго нь хог хаягдлын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, иргэдийн дадлыг төлөвшүүлэх, дахин боловсруулах үйлдвэрийн түүхий эдийн чанарыг сайжруулахад чиглэнэ.



**ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД:**

Төв оффис, үйлдвэрийн хог хаягдлын менежментийн хоёр үе шаттай судалгаа




"Плэйтайм 2024" наадмын хог хаягдлын менежментэд дэмжлэг үзүүлсэн



**СУДАЛГААНЫ ҮР ДҮН:**

Төв үйлдвэр болон оффист нийт 39 төрлийн хог хаягдал бүртгэгдэж, үүнээс 66.7% нь дахин ашиглах/боловсруулах боломжтой байна. 2025 онд бүх ажилтнуудад зориулсан сургалт зохион байгуулж, хог хаягдлыг зохистой хаях, дахин боловсруулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

## АЯНЫ ХҮРЭЭНД ХОГ ЦЭВЭРЛЭГЭЭ, МОД ТАРИХ ӨДӨРЛӨГҮҮД

АПУ ХК жил бүр "Тунгалаг Туул" аяны хүрээнд голын ай сав дагуух хог хаягдлыг цэвэрлэж, мод тарих уламжлалт өдөрлөгүүдийг зохион байгуулдаг. Энэ жил Улаанбаатар хотын Дунд гол, Туул гол болон Сэлэнгэ аймгийн Хараа голын эргээр нийт 20 га талбайд 200 гаруй ажилтан оролцож цэвэрлэгээ хийв.

Мөн "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэгт байрлах "Инчөн мөрөөдлийн төгөл"-д 1500 мод тарилаа. Уг байршил нь өмнө нь хур хогийн цэг байсан бөгөөд 2018 оноос хоёр улсын хамтарсан төслөөр ногоон орчин болгон хөгжүүлж байгаагаараа онцлог байлаа.



# ХҮЧИРХЭГЖСЭН ХАМТ ОЛОН

**ТОДОРХОЙЛСОН ЗОРИЛГО:**

Хамт олон, бусад гол оролцогч талууд маань хөгжиж дэвших боломж бүхий Монгол гэр бүлийн үнэт зүйлд нийцүүлсэн ажлын орчныг хөгжүүлснээрээ манлайлагч ажил олгогч болно.

2024 онд АПУ ХК хүний хөгжил, ажлын тэгш, хүртээмжтэй орчныг дэмжих олон талт үйл ажиллагааг өргөжүүлж, тогтвортой байгууллагын соёлыг бэхжүүллээ. Ажилтны сургалт хөгжлийн цаг нэмэгдэж, ажлын байрны тогтвортой байдал сайжирсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог нэмэгдүүлж, ажлын байр тохируулах, орчныг хүртээмжтэй болгох ажлууд хийв.



ХАБЭА-ийн 14 бодлогыг хэрэгжүүлж, 2024 онд үйлдвэрлэлийн осолгүй ажилласан. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг 9000 гаруй ажилтанд үзүүлсэн.

NOVA болон BOOSTIBE хөтөлбөрөөр ажилтны сайн сайхныг дэмжиж, АПУ Академи, орон сууцны дэмжлэг, хобби клубуудыг амжилттай хэрэгжүүлэв.






"Хамаг Монгол - Дэлхийд" соёлын фестивалиар хамт олны эв нэгдэл, авьяасыг нээн харуулсан арга хэмжээ зохион байгууллаа.




2024 онд бид "INNOV-TALENT" инновацлаг ур чадварын тэтгэлэгт хөтөлбөрийг олон нийтэд зарлалаа. Бид 'Маргаашийн Манлайлагчид' 100 оюутны тэтгэлэгт хөтөлбөрийг зохион байгуулж байсан бөгөөд 2024 оны хувьд шинэлэг, хүртээмжтэй байдлаар хөтөлбөрийн санааг боловсруулж, хэрэгжүүлэхээр боллоо. Уг хөтөлбөрт сонгон шалгарсан 100 оюутан:

- Хувь хүний болон мэргэжлийн ур чадваруудыг нэмэгдүүлэх АПУ Академийн сургалтууд, коучинг хөтөлбөр, хувь хүний хөгжлийн сургалтын багцад (LMS NOVA) хамрагдах
- Мэргэжлийн дадлагаа ажлын бодит орчинд цалинтай хийх
- 2 сая төгрөгийн сургалтын төлбөрийн тэтгэлэг авах
- Бодит бизнесийн кэйс дээр ажиллаж, инновацлаг төсөл хэрэгжүүлэх
- Нийгэмд чиглэсэн сайн дурын ажил хийнэ.



**ТОДОРХОЙЛСОН ЗОРИЛГО:**

Өдөр тутмын амьдрал болон хэрэглээнд эрүүл сонголтуудыг сайжруулж, боломжийг нэмснээр Монгол мөн чанар шингэсэн зохистой амьдралын хэв маягийг дэвжээнэ.

**ХАРИУЦЛАГАТАЙ ХЭРЭГЛЭЭГ ДЭМЖИХ НЬ**

АПУ ХК нь бүтээгдэхүүнээ хариуцлагатай хэрэглээнд уялдуулан түгээх зорилгоор олон нийтийн боловсролд чиглэсэн "Гайхамшигт жолооч" аян, 21+ насны контент зэрэг олон нийтийн боловсрол, хандлагын өөрчлөлтөд чиглэсэн арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.

**ЭРҮҮЛ МЭНДЭД ЭЭЛТЭЙ ШИНЭЧЛЭЛ**

Эрүүл хэрэглээг дэмжих зорилгоор 5% агууламжтай бүтээгдэхүүнүүдээ 3.5% болгон шинэчилж, спиртийн агууламжийг бууруулсан бүтээгдэхүүнүүдийг танилцууллаа. Мөн:

**Healthy Water**
электролит, эрдсээр баяжуулсан ус




**Pro+**
Сафрон цэцэгтэй, тослоггүй, эрүүл мэндийн сүү




**АПУ Дэйри**
органик цуглам, гэрчилгээтэй органик сүүн бүтээгдэхүүнүүдийг зах зээлд нэвтрүүллээ.






## СПОРТЫГ ДЭМЖИХ, ИДЭВХТЭЙ АМЬДРАЛД УРИАЛАХ НЬ

Спорт бол эв нэгдэл, сахилга бат, эрүүл мэндийн бэлгэ тэмдэг. АПУ ХК нь спортын үнэ цэнийг эрхэмлэн, Central TV-тэй хамтран дараах олон улсын тэмцээнүүдийн Монгол дахь шууд дамжуулалтын албан ёсны эрхийг авлаа:

**UEFA EURO 2024**



**Paris 2024 Зуны Олимп**



**Paris 2024 Паралимп**



## МӨН ҮНДЭСНИЙ БОЛОН ОЛОН УЛСЫН СПОРТЫН АРГА ХЭМЖЭЭНҮҮДИЙГ ДАРААХ БАЙДЛААР ДЭМЖИН АЖИЛЛАЛАА

- Шагайн харваа, бөхийн барилдаан, морин уралдаан, сурын харваанд тамирчдаа дэмжив
- Монголын сагсан бөмбөгийн The League-ийн стратегийн түншээр үргэлжлүүлэн ажиллав
- Уулын гүйлтийн олон улсын SENGU RACE 2024 тэмцээнийг ивээн тэтгэв



ТОГТВОРТОЙ ТҮНШ

**ТОДОРХОЙЛСОН ЗОРИЛГО:**

Монголын нэлттэй хувьцаат компаниудын дунд байгаль орчин, нийгэм, засаглалын нөлөөллөөрөө жишиг байгууллага байна.

АПУ ХК нь урт хугацааны, хариуцлагатай, харилцан ашигтай хамтын ажиллагааг эрхэмлэн ханган нийлүүлэгчидтэйгээ ил тод, ёс зүйтэй харилцахыг зорьдог.

## 2024 ОНД БИД

- Хариуцлагатай худалдан авалтын удирдамжийг шинэчилж,
- Ёс зүйн дүрэм, нийлүүлэлтийн эрсдэлийн үнэлгээг сайжруулаа.




АПУ ХК нь 2022 оноос хойш ToC – Тогтвортой санхүүгийн холбоо-ны дэмжигч гишүүнээр элссэн бөгөөд бид салбар хооронд тогтвортой хөгжил, ил тод байдал, хариуцлагын зарчмыг сурталчлахад хувь нэмрээ оруулан ажиллаж байна.




**ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА**

2024 онд НҮБ-ын Суурин зохицуулагч Тапан Мишра манай "Монгол Бяслаг" болон "Шигүдэри" үйлдвэртэй танилцаж, сүүний үйлдвэрлэлийн инновац, орон нутгийн хөгжлийн үйл ажиллагааг өндрөөр үнэлсэн юм. Мөн АПУ ХК нь UNICEF-ийн "Blue Day" хандивын арга хэмжээнд Silver Sponsor-оор оролцож, хүүхдийн хөгжил, хамгааллыг дэмжсэн олон улсын санаачилгыг дэмжлээ.

## БИЗНЕСИЙН ЁС ЗҮЙ

АПУ компанид ТУЗ-өөс 2023 оны 02 сарын 13-ны өдөр батлагдсан "Бизнесийн ёс дүрэм" багц бодлогын баримт бичиг хүчин төгөлдөр үйлчилж байгаа бөгөөд АПУ ХК болон түүний охин компаниудын бүхий л ажилтнууд үйл ажиллагаандаа ёс зүйн бодлого, дүрмийг мөрдлөг болгон ажиллаж байна.

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Хүний эрхийн бодлого | Өрсөлдөөний бодлого | Авлигаас урьдчилан сэргийлэх бодлого | Бэлэг, хандивын бодлого | Мөнгө угаахтай тэмцэх, хориг арга хэмжээний бодлого | Ашиг сонирхлын зөрчлийн бодлого | Компанийн хөрөнгө ашиглах бодлого |
| Залилангийн эсрэг бодлого | Нууц мэдээллийн бодлого | Оюуны өмчийн бодлого | Олон нийтийн сүлжээ ашиглах бодлого | Согтууруулах ундааны хариуцлагатай хэрэглээний бодлого | Нийлүүлэгчийн дүрэм | Сахилгын арга хэмжээний бодлого |

### Үргэлж "Ёс зүй" Өөдөө

Бид баримталдаг зарчмаа эрхэмлэж, ёс зүйн бодлого, дүрмийн сургалтыг ажилтан бүрд явуулдаг ба 2024 онд MS 365 - Learning Management System [LMS], Nova LMS цахим сургалтын платформоор дамжуулан нийт 369 ажилтанд орсон байна.







### Шүгэл үлээх сувгууд:

Цахимаар:
- Web site: www.speakup.apu.mn
- E-mail: speakup@apu.mn

Биечлэн:
- Шууд удирдлагадаа мэдэгдэх;
- Захиргаа, хүний нөөцийн газар, Хуулийн алба, Үйл явц хяналт сайжруулалтын албаны ажилтнуудад мэдэгдэх;
- Байршил бүр дээр сонгогдсон Итгэмжлэгдсэн төлөөлөгчдөөр дамжуулан мэдээлэл гаргах боломжтой.



# 05

# САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

Дэлгэрэнгүй орлогын тайлан
Санхүү байдлын тайлан
Мөнгөн гүйлгээний тайлан
Өмчийн өөрчлөлтийн тайлан
Тайлагналын зарчим
Тайлбар толь

# ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

| | | Аудитлагдсан НСТ 2024 | Аудитлагдсан НСТ 2023 |
|---|---|---|---|
| Борлуулалтын орлого (цэвэр) | сая.төг | 1,327,523 | 1,105,352 |
| Борлуулалтын өртөг | сая.төг | (680,502) | (625,950) |
| **Нийт ашиг ( алдагдал)** | **сая.төг** | **647,020** | **479,402** |
| Борлуулалт, удирдлагын зардал | сая.төг | (368,798) | (299,608) |
| Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт | сая.төг | (4,435) | (81) |
| Бусад орлого | сая.төг | 7,844 | 6,355 |
| Бусад зардал | сая.төг | (14,574) | (10,722) |
| **Үйл ажиллагааны ашиг** | **сая.төг** | **267,057** | **175,345** |
| Санхүүгийн орлого | сая.төг | 5,016 | 1,938 |
| Санхүүгийн зардал | сая.төг | (30,554) | (19,619) |
| **Татварын өмнөх ашиг** | **сая.төг** | **241,519** | **157,663** |
| Орлогын албан татварын зардал | сая.төг | (48,628) | (40,605) |
| **Тайлант үеийн цэвэр ашиг** | сая.төг | 192,891 | 117,058 |
| **Бусад дэлгэрэнгүй орлого** | | | |
| Ашиг, алдагдал руу дахин ангилагдахгүй зүйлс: | | | |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ | сая.төг | - | 2,334 |
| Ажилчдын тэтгэмжийн дахин хэмжилтийн алдагдал | сая.төг | (174) | (434) |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | сая.төг | (401) | (760) |
| **Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого** | **сая.төг** | **192,316** | **118,198** |
| Толгой компанийн хувьцаа эзэмшигчдэд ноогдох | сая.төг | 222,474 | 146,795 |
| Хяналтын эрхгүй хувь оролцоонд ноогдох | сая.төг | (29,583) | (29,736) |
| **Тайлант үеийн цэвэр ашиг** | **сая.төг** | **192,891** | **117,058** |
| Толгой компанийн хувьцаа эзэмшигчдэд ноогдох | сая.төг | 221,900 | 147,934 |
| Хяналтын эрхгүй хувь оролцоонд ноогдох | сая.төг | (29,583) | (29,736) |
| **Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлогын нийт дүн** | **сая.төг** | **192,316** | **118,198** |
| Нэгж хувьцаанд ноогдох ашиг | | | |
| Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг /алдагдал/ | сая.төг | 209.1 | 137.9 |

# САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

| | | Аудитлагдсан НСТ 2024 | Аудитлагдсан НСТ 2023 |
|---|---|---|---|
| Хөрөнгө | | | |
| Үндсэн хөрөнгө | сая.төг | 535,763 | 498,808 |
| Биет бус хөрөнгө ба гүүдвил | сая.төг | 68,384 | 69,117 |
| Хойшлогдсон татварын хөрөнгө | сая.төг | 3,343 | 981 |
| Биологийн хөрөнгө | сая.төг | 628 | 624 |
| Бусад эргэлтийн бус хөрөнгө | сая.төг | 10,876 | |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | **сая.төг** | **618,993** | **569,529** |
| Бараа материал | сая.төг | 206,905 | 221,238 |
| Урьдчилгаа, урьдчилж төлсөн зардал | сая.төг | 38,116 | 27,781 |
| Орлогын албан татварын авлага | сая.төг | 3,632 | 7,833 |
| Дансны болон бусад авлага | сая.төг | 117,524 | 69,307 |
| Бусад санхүүгийн хөрөнгө оруулалт | сая.төг | | - |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | сая.төг | 92,974 | 122,152 |
| Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө | сая.төг | 411 | 642 |
| **Эргэлтийн хөрөнгө** | **сая.төг** | **459,563** | **448,952** |
| **Нийт хөрөнгө** | **сая.төг** | **1,078,556** | **1,018,481** |

| | | | |
|---|---|---|---|
| Эздийн өмч | | | |
| Хувьцаат капитал | сая.төг | 106 | 106 |
| Нэмж төлөгдсөн капитал | сая.төг | 339,443 | 339,443 |
| Нэгдлийн нөөц | сая.төг | (112,796) | (112,796) |
| Дахин үнэлгээний нөөц | сая.төг | 156,573 | 157,839 |
| Гадаад валютын хөрвүүлгийн нөөц | сая.төг | (457) | (57) |
| Хуримтлагдсан ашиг | сая.төг | 392,483 | 274,270 |
| Хяналтын эрхгүй хувь оролцоо | сая.төг | 19,648 | 21,770 |
| **Нийт эздийн өмч** | **сая.төг** | **795,000** | **680,576** |
| Өр төлбөр | | | |
| Хойшлогдсон татварын өглөг | сая.төг | 25,485 | 29,888 |
| Урт хугацаат бусад өглөг | сая.төг | 5,878 | - |
| Урт хугацаат түрээсийн өглөг | сая.төг | 37,986 | 41,528 |
| Ажилтны тэтгэмж | сая.төг | 1,309 | 990 |
| Урт хугацааны зээл | сая.төг | 61,384 | 107,392 |
| Бусад урт хугацаат өр төлбөр | сая.төг | 1,828 | 432 |
| **Урт хугацаат өр төлбөр** | **сая.төг** | **133,870** | **180,231** |
| Богино хугацаат түрээсийн өглөг | сая.төг | 19,233 | 18,593 |
| Орлогын албан татварын өглөг | сая.төг | 985 | 1,563 |
| Дансны өглөг | сая.төг | 51,714 | 53,083 |
| Бусад өглөг | сая.төг | 55,249 | 44,435 |
| Богино хугацаат зээл | сая.төг | 22,505 | 40,000 |
| **Богино хугацаат өр төлбөр** | **сая.төг** | **149,687** | **157,674** |
| **Нийт өр төлбөр** | **сая.төг** | **283,556** | **337,906** |
| **Нийт өр төлбөр ба эздийн өмч** | **сая.төг** | **1,078,556** | **1,018,481** |

# МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

| | | Аудитлагдсан НСТ 2024 | Аудитлагдсан НСТ 2023 |
|---|---|---|---|
| **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | | |
| Тайлант жилийн ашиг | сая.төг | 192,891 | 117,058 |
| Тохируулга: | сая.төг | | |
| Орлогын албан татварын зардал | сая.төг | 48,628 | 40,605 |
| Зээлийн хүүгийн зардал | сая.төг | 14,999 | 10,329 |
| Түрээсийн хүүгийн зардал | сая.төг | 9,339 | 7,647 |
| Деривaтив санхүүгийн өр төлбөрийн хүүгийн зардал | сая.төг | 3,495 | 964 |
| Нөөцийн дискаунтын чөлөөлөлт | сая.төг | 185 | 215 |
| Хүүгийн орлого | сая.төг | (5,016) | (1,545) |
| Валютын ханшийн тэгшитгэлийн хэрэгжээгүй гарз/(олз), цэвэр | сая.төг | 633 | 55 |
| Элэгдлийн зардал | сая.төг | 76,946 | 75,198 |
| Хорогдуулгын зардал | сая.төг | 7,671 | 7,666 |
| Дансны болон бусад авлагын үнэ цэнийн бууралт, (цэвэр) | сая.төг | - | - |
| Банкны үлдэгдэл дэх үнэ цэнийн бууралт | сая.төг | (41) | 261 |
| Урьдчилж төлсөн төлбөрийн үнэ цэнийн бууралт | сая.төг | - | - |
| Бараа материалын үнэ цэнийн бууралт | сая.төг | - | - |
| Данснаас хассан бараа материал | сая.төг | - | - |
| Үндсэн хөрөнгө борлуулсны олз | сая.төг | (150) | (117) |
| Үндсэн хөрөнгө борлуулсны гарз | сая.төг | 1,219 | 295 |
| Хасагдсан үндсэн хөрөнгө | сая.төг | 475 | 714 |
| Үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралт | сая.төг | - | 2,336 |
| Деривaтив санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн алдагдал | сая.төг | 1,396 | 432 |
| Биологийн хөрөнгө борлуулсаны гарз | сая.төг | 72 | 269 |
| Биологийн хөрөнгө данснаас хассаны гарз | сая.төг | 24 | - |
| Биет бус хөрөнгө борлуулсны гарз | сая.төг | - | - |
| Өмчийн төлбөр тооцооны гүйлгээ | сая.төг | - | 1,348 |
| | **сая.төг** | **352,764** | **263,731** |

| | | Аудитлагдсан НСТ 2024 | Аудитлагдсан НСТ 2023 |
|---|---|---|---|
| **Хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлт:** | | | |
| Дансны авлага болон бусад авлага | сая.төг | (33,643) | (19,247) |
| Бараа материал | сая.төг | 16,170 | (34,656) |
| Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө | сая.төг | 231 | 67 |
| Урьдчилгаа | сая.төг | (6,974) | 24,684 |
| Дансны өглөг | сая.төг | (464) | 2,935 |
| Бусад өглөг | сая.төг | 10,916 | (3,280) |
| Ажилтны тэтгэмж | сая.төг | 336 | (326) |
| | **сая.төг** | **339,336** | **233,907** |
| Зээлийн хүүний төлбөрт төлсөн | сая.төг | (14,999) | (10,329) |
| Түрээсийн хүүний төлбөрт төлсөн | сая.төг | (9,339) | (7,647) |
| Деривативын санхүүгийн өр төлбөрийн хүүний төлбөр төлсөн | сая.төг | (3,457) | (368) |
| Хүлээн авсан хүүгийн орлого | сая.төг | 5,016 | 1,545 |
| Төлсөн орлогын албан татвар | сая.төг | (51,760) | (32,725) |
| **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | **сая.төг** | 264,798 | **184,383** |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | | |
| Худалдаж авсан үндсэн хөрөнгө | сая.төг | (112,185) | (117,750) |
| Худалдаж авсан биет бус хөрөнгө | сая.төг | (6,894) | (2,738) |
| Худалдаж авсан хяналтын бус хувь оролцоо | сая.төг | - | - |
| Худалдаж авсан бусад санхүүгийн хөрөнгө | сая.төг | (15,000) | |
| Борлуулсан үндсэн хөрөнгө | сая.төг | 9,787 | 3,911 |
| Бусад санхүүгийн хөрөнгө оруулалтыг олж эзэмшихэд төлсөн | сая.төг | (100) | (892) |
| Бусад санхүүгийн хөрөнгө оруулалт борлуулсан | сая.төг | | - |
| **Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ** | **сая.төг** | **(124,392)** | **(117,469)** |
| **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | | |
| Зээлийн эргэн төлөлт | сая.төг | (100,906) | (105,900) |
| Төлсөн ногдол ашиг | сая.төг | (104,868) | (111,481) |
| Түрээсийн өглөгт төлсөн | сая.төг | (27,184) | (15,680) |
| Хяналтын эрхгүй хувь оролцоонд ногдох | сая.төг | 27,461 | 21,343 |
| Урт хугацааны зээл авсан | сая.төг | 37,230 | 230,570 |
| **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | **сая.төг** | **(168,266)** | **18,853** |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | сая.төг | (781) | (921) |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт / (бууралт)** | **сая.төг** | **(28,641)** | **84,845** |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | сая.төг | 122,152 | 38,365 |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн үнэ цэнийн бууралт | сая.төг | 41.16 | (261.38) |
| Мөнгөн хөрөнгө дэх гадаад валютын ханшийн хэлбэлзлийн нөлөөлөл | сая.төг | (577.54) | (796.85) |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **сая.төг** | **92,974** | **122,152** |

# ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

| ҮЗҮҮЛЭЛТ | | Хувьцаат капитал | Нэмж төлөгдсөн капитал | Нэгдлийн нөөц | Дахин үнэлгээний нөөц | Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн | Хяналтын эрхгүй хувь оролцоо | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **2023 эхний үлдэгдэл /нэгтгэсэн/** | **сая.төг** | **106** | **338,095** | **(112,796)** | **156,567** | **704** | **220,739** | **603,414** | **30,163** | **633,577** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | сая.төг | - | - | - | - | - | - | - | - | - |
| **2023 эхний үлдэгдэл /нэгтгэсэн/** | **сая.төг** | **106** | **338,095** | **(112,796)** | **156,567** | **704** | **220,739** | **603,414** | **30,163** | **633,577** |
| Нийт дэлгэрэнгүй орлого | сая.төг | - | - | - | - | - | - | - | - | - |
| Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал ) | сая.төг | - | - | - | - | - | 146,795 | 146,795 | (29,736) | 117,058 |
| Бусад дэлгэрэнгүй орлого | сая.төг | - | - | - | 2,334 | (760) | 280 | 1,854 | - | 1,854 |
| Зарласан ногдол ашиг | сая.төг | - | - | - | - | - | (94,605) | (94,605) | - | (94,605) |
| Худалдаж авсан хяналтын эрхгүй хувьцаа | сая.төг | - | - | - | - | - | - | - | - | - |
| Нэмэгдүүлсэн хувьцаат капитал | сая.төг | - | 1,348 | - | - | - | - | 1,348 | 21,343 | 22,691 |
| Хуримлагдсан ашиг руу шилжүүлсэн | сая.төг | - | - | - | (1,062) | - | 1,062 | - | - | - |
| **2023 эцсийн үлдэгдэл /нэгтгэсэн/** | **сая.төг** | **106** | **339,443** | **(112,796)** | **157,839** | **(57)** | **274,270** | **658,806** | **21,770** | **680,576** |
| Нийт дэлгэрэнгүй орлого | сая.төг | - | - | - | - | - | - | - | - | - |
| Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал ) | сая.төг | - | - | - | - | - | 222,474 | 222,474 | (29,583) | 192,891 |
| Бусад дэлгэрэнгүй орлого | сая.төг | - | - | - | - | (401) | (174) | (574) | - | (574) |
| Зарласан ногдол ашиг | сая.төг | - | - | - | - | - | (105,354) | (105,354) | - | (105,354) |
| Худалдаж авсан хяналтын эрхгүй хувьцаа | сая.төг | - | - | - | - | - | - | - | - | - |
| Нэмэгдүүлсэн хувьцаат капитал | сая.төг | - | - | - | - | - | - | - | 27,461 | 27,461 |
| Хуримлагдсан ашиг руу шилжүүлсэн | сая.төг | - | - | - | (1,266) | - | 1,266 | - | - | - |
| **2024 эцсийн үлдэгдэл /нэгтгэсэн/** | **сая.төг** | **106** | **339,443** | **(112,796)** | **156,573** | **(458)** | **392,483** | **775,352** | **19,648** | **795,000** |

# ТАЙЛАГНАЛЫН ЗАРЧИМ

### ТАЙЛАГНАЛЫН НИЙЦЭЛ

Нэгтгэсэн санхүүгийн тайланг Монгол улсын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актын хүрээнд бэлтгэсэн.

Уг тайланг Санхүүгийн тайлангийн Олон Улсын Стандарт ("СТОУС") 10 буюу "Нэгтгэсэн санхүүгийн Тайлан" хэмээх стандартын арга аргачлалыг ашиглан бэлтгэсэн.

### ҮНЭЛГЭЭНИЙ СУУРЬ

Энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайланг толилуулахдаа санхүүгийн тайланг түүхэн өртгийн зарчимд үндэслэн бэлтгэсэн.

### БҮРТГЭЛИЙН БОЛОН ТОЛИЛУУЛГЫН ВАЛЮТ

Нэгтгэсэн санхүүгийн тайланг компанийн бүртгэлийн валют болох Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр толилуулсан бөгөөд энэ нь компанийн үйл ажиллагаа явуулж буй анхдагч эдийн засгийн орчны үндсэн валют болно.

### ТААМАГЛАЛ, ТООЦООЛОЛ БОЛОН ҮНЭЛЭМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

Нэгтгэсэн санхүүгийн тайланг СТОУС болон НББОУС-д нийцүүлэн бэлтгэх үйл явц нь таамаглал, тооцоолол, үнэлэмж хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү таамаглал, тооцоолол, үнэлэмж нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт, мөн хөрөнгө, өр төлбөр, орлого зардлын зүйлсийн дүнг тодорхойлоход нөлөөлдөг. Гүйцэтгэлээрх үр дүн нь эдгээр тооцооллоос зөрүүтэй байж болно. Удирдлага эдгээр тооцоолол болон түүнд хэрэглэсэн таамаглалыг байнга хянаж байдаг.

### ГАДААД ВАЛЮТААРХ АЖИЛ ГҮЙЛГЭЭ

Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлж бүртгэдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө, өр төлбөрийн мөнгөн зүйлсийг балансын өдрийн хаалтын ханшаар төгрөг рүү хөрвүүлэн илэрхийлдэг.

Бодит үнэ цэнээр хэмжигдэж, гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрийн зүйлсийг тухайн бодит үнэ цэнийг тодорхойлсон өдрийн албан ханшаар бүртгэлийн валют руу хөрвүүлдэг. Түүхэн өртгөөр хэмжигдэж, гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар тайлагнадаг.

### САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

ҮҮСМЭЛ БУС САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ. Компани нь зээл болон авлагыг анх үүссэн тухай бүр нь хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Бусад бүх санхүүгийн хөрөнгүүдийг (ашиг, алдагдлын дараах бодит үнэ цэнээр тодорхойлогдсон хөрөнгүүдийг оролцуулаад) хэлцэл хийгдсэн өдөр буюу тухайн санхүүгийн хэрэгслийн хувьд компани гэрээний нэг тал болсон өдрөөр хүлээн зөвшөөрдөг.

АВЛАГА. Уг хөрөнгийг бодит үнэ цэнэ дээр тухайн ажил гүйлгээтэй холбоотой гарсан шууд зардлыг нэмсэн дүнгээр анх хүлээн зөвшөөрдөг.

ҮҮСМЭЛ БУС САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨР. Компани нь гаргасан өрийн бичиг, өр төлбөрийг тухайн ажил гүйлгээг үүссэн өдрөөр хүлээн зөвшөөрч, бүртгэдэг. Бусад бүх санхүүгийн өр төлбөрийг (ашиг, алдагдлын дараах бодит үнэ цэнээр тодорхойлогдсон хөрөнгүүдийг оролцуулаад) хэлцэл хийгдсэн өдөр буюу тухайн санхүүгийн хэрэгслийн хувьд компани гэрээний нэг тал болсон өдрөөр хүлээн зөвшөөрдөг.

### САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ, ӨР ТӨЛБӨРИЙГ ЦЭВЭР ДҮНГЭЭР ТУСГАХ.

Компани хүлээн зөвшөөрөгдсөн дүнг хооронд нь хаах хууль эрх зүйн эрхтэй байх, мөн цэвэр дүнгээр нь төлбөр хийх эсвэл нэгэн зэрэг хөрөнгийг борлуулах, өр төлбөрийг барагдуулах зорилготой үед санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хааж санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр нь тусгадаг.

### ҮНДСЭН ХӨРӨНГӨ АНХДАГЧ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ.

Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж буй үндсэн хөрөнгийн зүйлсийг анхны удаа өртгөөр нь хэмждэг. Өртөгт тухайн хөрөнгийг худалдан авахтай шууд холбогдон гарсан зардлууд багтдаг.

### ДАРАА ҮЕИЙН ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ.

Барилга байгууламж, газар, тоног төхөөрөмжийн бүлэг үндсэн хөрөнгийг хөрөнгөөр хүлээн зөвшөөрсний дараа түүний бодит үнэ цэнийг илтгэх дахин үнэлсэн дүнгээр хэмжих ба дахин үнэлсэн дүн нь дараа үеийн хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүн байдаг. Хөрөнгийн бодит үнэ цэнийг Монгол Улсын хараат бус үнэлгээчин тогтоодог.

ДАРАА ҮЕИЙН ЗАРДАЛ.

Дараа үеийн зардлыг зөвхөн эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг хүртэх магадлалтай гэдэг нь тогтоогдсон үед капиталжуулан бүртгэдэг. Урсгал засварын зардлыг гарсан тухайн тайлант үед зардлаар хүлээн зөвшөөрдөг.

ЭЛЭГДЭЛ.

Үндсэн хөрөнгийн зүйлсийг бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн ашиглалтын жилээр тооцон шулуун шугамын аргаар элэгдүүлж, орлогын тайланд бүртгэдэг. Үндсэн хөрөнгийг түүнийг байршуулж, ашиглахад бэлэн болсон үеэс нь, дотооддоо барьж байгуулсан хөрөнгийн хувьд тэдгээрийг дуусгавар болгож, үйл ажиллагаа явуулахад бэлэн болсон үеэс нь эхлэн элэгдэл байгуулдаг.

БИЕТ БУС ХӨРӨНГӨ

Компани биет бус хөрөнгө худалдан авсан бөгөөд түүний ашиглалтын жилийг тодорхойлох боломжтой бол түүний өртгөөс хуримтлагдсан хорогдуулга болон үнэ цэнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр тайлагнадаг.

БИОЛОГИЙН ХӨРӨНГӨ

Биологийн хөрөнгийг борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнээр нь хэмжих бөгөөд үүнтэй холбоотой үүсэх олз ба гарзыг тухайн тайлант үеийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

ЗЭЭЛИЙН ӨРТӨГ

Компани бэлтгэл шаардагдах хөрөнгийн худалдан авалт, барилгын ажил эсвэл үйлдвэрлэлтэй шууд хамааралтай зээлийн өртгийг тухайн хөрөнгийн өртгийн хэсэг болгон капиталжуулдаг. Бусад зээлийн өртгийг гарсан тайлант үед нь зардлаар хүлээн зөвшөөрдөг.

БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнийн аль багаар үнэлдэг. Бараа материалын өртгийг дундаж өртгийн аргаар тодорхойлох бөгөөд бараа материалын өртөгт худалдан авалтын өртөг, хувиргалтын зардал болон одоогийн байршил ба нөхцөлд бараа материалыг авчрахтай холбогдож

гарсан бүх зардлууд ордог. Үйлдвэрийн бараа материал, дуусаагүй үйлдвэрлэлийн хувьд хэвийн хүчин чадлаар ажиллах үеийн үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлын зохих хэсгийг өртөгт хуваарилдаг.

ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ ҮҮСМЭЛ БУС САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ

Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдээгүй санхүүгийн хөрөнгийн хувьд тэдгээрт үнэ цэнийн бууралт үүссэн гэдэг бодит нотолгоо байгаа эсэхийг тайлант хугацааны эцэс бүрт үнэлж тодорхойлдог.

ХОРОГДУУЛСАН ӨРТГӨӨР ИЛЭРХИЙЛСЭН САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ.

Компани эдгээр хөрөнгүүдийг тусад нь мөн хамтад нь үнэ цэнийн бууралтын нотолгоо байгаа эсэхийг үздэг. Бүх мэдэгдэхүйц хэмжээний хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг тусад нь үнэлнэ.

САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГӨ.

Тайлант үеийн эцэст бараа материал, хойшлогдсон татварын хөрөнгөөс бусад санхүүгийн бус хөрөнгийн дансны үнэнд үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг байгаа эсэхийг үнэлдэг. Хэрэв ийм шинж тэмдэг илэрсэн бол тухайн хөрөнгийн нөхөгдөх боломжтой үнийг тодорхойлно.

АЖИЛЧДЫН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, УРАМШУУЛАЛ

АЖИЛЧДЫН БОГИНО ХУГАЦААТ ТЭТГЭМЖ. Холбогдох үйлчилгээ үзүүлсэн үед ажилчдын богино хугацаат тэтгэмжийг зардлаар бүртгэдэг. Компани нь ажилтны үзүүлсэн үйлчилгээний дагуу компанид үүрэг хариуцлага үүссэнээс найдвартайгаар тооцоолж болох компанийн төлөх ёстой дүнгээр өр төлбөрөө хүлээн зөвшөөрдөг.

ТОГТООСОН ШИМТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ. Ажилчдын тэтгэвэр, тэтгэмж нь Монгол Улсын Нийгмийн Даатгалын Санд төвлөрүүлэх хуулиар тогтоосон нийгмийн даатгалын шимтгэлээс бүрдэнэ. Тодорхой шимтгэлийн дүн бүхий тэтгэвэр, тэтгэмжийн хөтөлбөрт төвлөрүүлэх шимтгэлийг түүнийг төлөх үүрэг хүлээсэн тайлант үеийн зардлаар бүртгэдэг.

НӨӨЦ БА БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР

Компани өнгөрсөн үйл явдлын үр дүнд өнөөгийн хуулиар хүлээсэн эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн, уг үүрэг хариуцлагын төлбөрийг барагдуулахад эдийн засгийн өгөөж бүхий нөөц шаардлагатай гэдэг нь тодорхой болсон ба үүрэг хариуцлагын дүнг найдвартай тооцоолох боломжтой болсон үед санхүүгийн байдлын тайланд нөөцийг хүлээн зөвшөөрдөг.

ХУВЬЦААТ КАПИТАЛ

ЭНГИЙН ХУВЬЦАА.

Энгийн хувьцааг эздийн өмчийн хэсэгт ангилж, бүртгэдэг. Энгийн хувьцаа нэмж гаргахтай холбоотой нэмэгдэл зардлыг татварын нөлөөллийн дараах цэвэр дүнгээр нь эздийн өмчийн бууралтаар хүлээн зөвшөөрдөг.

ХАЛААСНЫ ХУВЬЦАА.

Хувьцаат капиталыг буцаан худалдан авсан үед аливаа татварын нөлөөллийн дараах худалдан авахтай холбоотой гарсан шууд зардлыг багтаасан дүнгээр эздийн өмчийн бууралт гэж бүртгэдэг.

Буцаан худалдан авсан хувьцааг халаасны хувьцаа гэж нэрлэх бөгөөд өмчийн өөрчлөлтийн тайланд халаасны хувьцаа гэж тайлагнадаг. Халаасны хувьцааг дахин борлуулсан эсвэл дахин эргэлтэнд гаргасан үед хүлээн авсан дүнг өмчийн өсөлтөөр бүртгэдэг бөгөөд тухайн ажил гүйлгээтэй холбогдон гарсан өсөлт, бууралтыг нэмж төлөгдсөн капитал гэж толилуулдаг.

## ХУВЬЦААТ КАПИТАЛ, НЭМЖ ТӨЛӨГДСӨН КАПИТАЛ БА БУСАД НӨӨЦҮҮД

Эвэргрийн Инвестментс ХХК-тай нэгдсэн талаар

Холбогдох эрх бүхий байгууллагуудаас зохих зөвшөөрлүүдийг шат дараатай авсны үндсэн дээр нэгдлийн ажил гүйлгээ 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрөөр дуусгавар болсон. Эцсийн үе шатанд Эвэргрийн Инвестментс ХХК компанид нэгдсэн бөгөөд компани нь нэгдсэн компаниуд, тэдгээрийн охин компаниудын толгой компани болсон.

Нэгдлийн үр дүнд дараах өмчийн дахин зохион байгуулалтыг хийсэн.

2017 оны 8 дугаар сарын 18-ны өдөр компанийн хувьцаа эзэмшигчид нийт 338,127,000 мянган төгрөгөөр капиталыг нэмэгдүүлэх замаар Эвэргрийн Инвестментс ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд нийт 321,305 мянган ширхэг энгийн хувьцааг шинээр гаргасан. Уг капитал нь 32,130 мянган төгрөгийн хувьцаат капитал болон 338,094,870 мянган төгрөгийн нэмж төлөгдсөн капиталаас бүрдсэн.

Нэгдлийн нөөц

Бизнесийн нэгдлийн хүрээнд компанийн шилжүүлсэн төлбөр нь Эвэргрийн Инвестментс ХХК-тай хийсэн нэгдэлд зориулж шинээр гаргасан хувьцаа болно. Өмчийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тодорхойлохдоо бодит үнэ цэнийн 1 дүгээр шатлалын хэмжүүр болох компанийн хувьцааны зах зээлийн үнэ цэнийг ашигласан. Нэмж гаргасан хувьцааны бодит үнэ цэнэ болон хуулийн дагуу бүртгэгдсэн үнэ цэнийн зөрүү болох 112,795,804 мянган төгрөгийг нэгдлийн нөөц гэж бүртгэсэн.

## ОРЛОГО

Бараа борлуулалтын орлогыг хүлээн авсан эсвэл хүлээн авахаар хүлээгдэж буй төлбөрийн бодит үнэ цэнээр хэмжиж бүртгэлд тусгадаг. Ингэхдээ компани эдийн засгийн өгөөжийг хүртэх магадлал өндөр бөгөөд орлого ба өртөг зардлыг бодитоор хэмжих боломжтой байх ёстой.

## БАРАА БОРЛУУЛАЛТ

Бараа агуулахаас ачигдан, худалдан авагчийн талбайд хүргэгдэж, худалдан авагч барааг хүлээн авч, эрсдэл болон өмчлөл нь худалдан авагчид бүрэн шилжсэн тохиолдолд орлогыг хүлээн зөвшөөрдөг. Орлогын дүнд нэмэгдсэн өртгийн албан татвар болон бусад борлуулалтын татварыг оруулдаггүй ба худалдааны хөнгөлөлт, урамшууллыг хассан цэвэр дүн байдаг.

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТҮРЭЭСИЙН ОРЛОГО

Үйл ажиллагааны түрээсийн орлогыг түрээсийн хугацааны туршид төлөгдөх ижил хэмжээний хэсэгчилсэн төлөлтөөр орлогын тайланд хүлээн зөвшөөрч, бүртгэдэг. Хүлээн авсан түрээсийн хөрөнгийн урамшууллыг түрээсийн нийт зардлын дүнд тооцон түрээсийн хугацааны туршид хүлээн зөвшөөрдөг. Болзошгүй түрээсийн орлогыг тухайн орлогыг олсон тайлант хугацаанд хүлээн зөвшөөрдөг.

## БУСАД ОРЛОГО

Компанийн үндсэн үйл ажиллагаанаас гадна бий болж буй орлогыг бусад орлого гэх бөгөөд тухайн орлогын эдийн засгийн өгөөжийг компани хүртэх магадлалтай ба үүнийг найдвартай хэмжин тодорхойлох боломжтой болсон үед компани бусад орлогыг хүлээн зөвшөөрдөг.

## САНХҮҮГИЙН ОРЛОГО БА САНХҮҮГИЙН ЗАРДАЛ

Санхүүгийн орлогод хөрөнгө оруулалтаас хүртэх хүүгийн орлого орно. Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн түвшин ашиглан тооцож, орлогын тайланд хуримтлуулан бүртгэдэг.

Санхүүгийн зардал нь зээлийн хүүгийн зардлаас бүрддэг. Зээлийн хүүгийн зардлыг үр ашигт хүүгийн түвшин ашиглан тооцож, орлогын тайланд бүртгэдэг.

## ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ЗАРДАЛ

Орлогын албан татварын зардал нь тайлант жилийн татвар болон хойшлогдсон татвараас бүрддэг. Тайлант жилийн татвар болон хойшлогдсон татварыг эздийн өмч эсвэл бусад дэлгэрэнгүй орлогоор шууд хүлээн зөвшөөрөхөөс бусад тохиолдолд дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрч, бүртгэдэг.

## НЭГЖ ХУВЬЦААНД НОГДОХ АШИГ

Компани энгийн хувьцааны хувьд нэгж хувьцаанд ногдох суурь ашгийг тооцоолдог. Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдэд хамаарах цэвэр ашиг, алдагдлыг тайлант хугацааны туршид эргэлтэнд байсан энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоонд хуваах замаар нэгж хувьцаанд ногдох суурь ашгийг тооцоолдог.

## ХОЛБООТОЙ ТАЛУУД

Аливаа хувь хүн эсвэл түүний гэр бүлийн ойр дотны гишүүнийг дараах тохиолдолд компанитай холбоотой гэж үзнэ:

- Компанийг хянадаг эсвэл хамтран хянадаг;
- Компанид мэдэгдэхүйц нөлөөлөлтэй;
- Компанийн эсвэл түүний толгой компанийн тэргүүлэх удирдлагын гишүүн бол.

Хувь хүний гэр бүлийн ойр дотны гишүүд гэдэг нь компанитай ажил хэргийн харилцаанд орох явцад хувь хүнд нөлөөлөх эсвэл түүний нөлөөнд автаж болзошгүй гэр бүлийн гишүүд юм.

# ТАЙЛБАР ТОЛЬ

Тайлант үе
Аж ахуйн нэгж, байгууллагын ашиг, алдагдлыг тооцож буй хугацааг хэлнэ. Ерөнхийдөө улирал, жилийг хамруулж авч үзнэ.

Санхүүгийн тайлан
Иж бүрэн санхүүгийн тайлан нь санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн тайлангийн тодруулгаас бүрдэнэ.

Хөрөнгө
Хөрөнгө гэдэг нь өнгөрсөн үйл ажиллагааны үр дүнд бий болж, байгууллагын мэдэлд орсон бөгөөд ирээдүйд үр өгөөжөө өгөх нөөц, баялаг, хөрөнгө юм.

ББХ-Биет бус хөрөнгө
Үндсэн хөрөнгөтэй адил биетээр, бодитоор оршдоггүй хэдий ч эзэмшигчдэдээ давуу тал болон давуу эрхийг олгодог патент, лиценз, зохиогчийн эрх, барааны тэмдэг, нэр төр, гүүдвил гэх мэт удаан хугацаанд үнэ цэнэтэй байх актив (хөрөнгө)-ыг хэлнэ.

ҮХ-Үндсэн хөрөнгө
Байшин, барилга, машин, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил гэх мэт худалдан борлуулах зориулалтгүй, үйлдвэрлэл, бизнесийн үйл ажиллагаанд урт хугацаанд ашиглагдах буюу 1 жилээс бага хугацаанд борлогдож мөнгөн хөрөнгө болохгүй хөрөнгийг хэлнэ.

ЭБХ-Эргэлтийн бус хөрөнгө
Үндсэн хөрөнгийг хэлнэ.

ЭХ-Эргэлтийн хөрөнгө
Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа тасралтгүй явуулахад ашиглагдах нэг жил буюу түүнээс бага хугацаанд бэлэн мөнгө болж хувирах хөрөнгийг хэлнэ.

УТЗ-Урьдчилж төлсөн зардал
Ажил үйлчилгээ авахаас өмнө буюу үр дүн нь гарахаас өмнө төлсөн төлбөр

Дансны Авлага
Үндсэн үйл ажиллагааны явцад борлуулсан бараа, бүтээгдэхүүн, узүүлсэн ажил, үйлчилгээний төлөө худалдан авагч болон холбоотой талаас авах мөнгөн дүн.

Бусад санхүүгийн хөрөнгө
3 сараас нэг жилийн хугацаатай хадгаламж, богино хугацаат хөрөнгө оруулалт хамаарна.

Мөнгөтэй түүнтэй адилтгах хөрөнгө
Үнэ цэнийг нь өөрчлөхөд өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, мөнгөнд шууд хөрвөх нэгээс гурван сарын хугацаатай хөрөнгө оруулалт юм.

Мөнгөн суурьт арга
Бэлнээр мөнгө хүлээж авсан үед нь орлогод, бэлнээр мөнгө төлсөн үед нь зардалд бүртгэх нягтлан бодох бүртгэлийн арга.

Аккруэл суурьт арга
Мөнгө хүлээн авсан, эсхүл төлснөөс үл хамаарах ажил үйлчилгээний гүйцэтгэлтэй уялдуулан орлогыг олсон, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэх аргыг хэлнэ.

Хувьцаат капитал
Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгө юм.

Дахин үнэлгээний нөөц
Аж ахуйн нэгжийн үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дансны үнэ дахин үнэлгээний үр дүнд өссөн дүнг хэлнэ.

Өр төлбөр
Бусдад төлөх ёстой мөнгө (хувь хүн, компани, эсхүл Засгийн газрын өр байж болно).

Урт хугацаат өр төлбөр
Нэг жилээс дээш хугацаанд төлөгдөх дотоодын болон гадаадын эх үүсвэр, холбоотой талаас авсан зээлийг хэлнэ.

Богино хугацаат өр төлбөр
12 сарын дотор төлбөр нь төлөгдөх өр төлбөрийг хэлнэ.

НДШ-Нийгмийн даатгалын шимтгэл
Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийг санхүүжүүлэх зорилгоор ажилчид болон ажил олгогчдод ногдуулах татвар.


APU COMPANY
Absolute. Pure. Unique.

*Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4 дүгээр хавсралт*

## Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/

*Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.*

| | |
|---|---|
| *Тайлагнах хугацаа* | 2024 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс<br>2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр |
| *Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар* | Нэр: АПУ ХУВЬЦААТ КОМПАНИ<br>УБГД: 000165753, РД: 2702673<br>ҮЦКод: APU /90/<br>Утас: 11-344336, 76002220 |
| *Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр* | Монголын хөрөнгийн бирж |
| *Бизнесийн үйл ажиллагааны салбар* | Шингэн хүнсний үйлдвэрлэл |
| *Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо* | “Кэй Пи Эм Жи Аудит” ХХК,<br>2013 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр |
| *Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг* | 1,064,181,553 |
| *Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр* | Санхүү, тайлагналын албаны дарга Ж.Оюумаа, ТУЗ, комплайнсын мэргэжилтэн Б.Мягмар, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Сарантунгалаг |

*1. Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/*

*Санхүүгийн байдлын үзүүлэлт*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|
| Хөрөнгө | | |
| Эргэлтийн хөрөнгө | 448,952,351,817 | 459,562,588,000 |
| Эргэлтийн бус хөрөнгө | 569,528,947,000 | 618,993,441,000 |
| **Нийт хөрөнгө** | **1,018,481,298,817** | **1,078,556,029,000** |
| Өр төлбөр ба эздийн өмч | | |
| Богино хугацаат өр төлбөр | 157,674,499,117 | 149,687,247,504 |
| Урт хугацаат өр төлбөр | 180,231,143,387 | 133,869,189,000 |
| Эздийн өмч | 680,575,656,313 | 794,999,592,496 |
| **Нийт өр төлбөр ба эздийн өмч** | **1,018,481,298,817** | **1,078,556,029,000** |

*Орлогын тайлан*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|
| Борлуулалтын орлого (цэвэр) | 1,105,352,126,000 | 1,327,522,591,000 |
| Борлуулалтын өртөг | (625,950,191,183) | (680,502,489,000) |
| **Нийт ашиг ( алдагдал)** | **479,401,934,817** | **647,020,102,000** |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | **157,663,407,644** | **241,518,700,000** |
| Орлогын татварын зардал | (40,605,307,000) | (48,627,848,000) |
| **Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)** | **117,058,100,644** | **192,890,852,000** |
| Бусад дэлгэрэнгүй орлого | 1,139,914,192 | (574,399,000) |
| **Нийт орлогын дүн** | **118,198,014,836** | **192,316,453,000** |
| Толгой компанийн хувьцаа эзэмшигчэд ноогдох | 147,934,472,836 | 221,899,869,000 |
| Хяналтын эрхгүй хувь оролцоонд ноогдох | (29,736,458,000) | (29,583,416,000) |

| | | |
|---|---|---|
| | *Өмчийн өөрчлөлтийн тайлан* | (table below) |

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|
| Өмч | 106,418,200 | 106,418,200 |
| Халаасны хувьцаа | - | - |
| Нэмж төлөгдсөн капитал | 226,646,951,296 | 226,646,951,296 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 157,839,025,854 | 156,572,931,000 |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | (56,565,000) | (457,461,000) |
| Хуримтлагдсан ашиг | 274,269,754,963 | 392,482,641,000 |
| **Нийт эздийн өмчийн дүн** | **658,805,585,313** | **775,351,480,496** |
| Хяналтын бус хувь оролцоо | 21,770,071,000 | 19,648,112,000 |
| **Нийт дүн** | **680,575,656,313** | **794,999,592,496** |

*Мөнгөн гүйлгээний тайлан*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|
| Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 184,382,607,000 | 264,797,959,000 |
| Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (117,469,073,000) | (124,392,028,000) |
| Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 18,853,189,000 | (168,266,198,000) |
| **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **85,766,723,000** | **(27,860,267,000)** |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 38,365,142,000 | 122,152,149,000 |
| Мөнгөн хөрөнгийн үнэ цэнийн бууралт болон валютын ханшийн өөрчлөлт | (1,979,716,000) | (1,317,558,000) |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **122,152,149,000** | **92,974,324,000** |

| | |
|---|---|
| 1.1. | *Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт* |
| | - Хавсралтаар оруулав. |
| 1.2. | *Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/* |
| | - Байхгүй. |
| 2. | *Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл* |

2.1. *Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/*

| Харьцаанууд | 2023 | 2024 |
|---|---|---|
| Нийт ашгийн хувь | 43% | 49% |
| Үйл ажиллагааны ашгийн хувь | 14% | 18% |
| Цэвэр ашгийн хувь | 11% | 15% |
| Өөрийн хөрөнгийн өгөөж | 18% | 25% |
| Нэгж хувьцаанд ногдох ашиг | 137,941.22 | 209,056.60 |

2.2. *Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт*

| Харьцаанууд | 2023 | 2024 |
|---|---|---|
| Эргэлтийн харьцаа | 2.85 | 3.07 |
| Түргэн хөрвөх чадварын харьцаа | 1.27 | 1.43 |
| Өр болон өөрийн хөрөнгийн харьцаа | 0.50 | 0.36 |

2.3. *Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл*

- 2024 онд инфляци болон гадаад валютын ханшийн нөлөөлөл харьцангүй тогтвортой байсан.
- Согтууруулах ундааны зах зээлд хэрэглэгч импортын бүтээгдэхүүний хэрэглээ рүү шилжиж байгаатай холбоотой дотоодын өрсөлдөөн улам нэмэгдэж байна
- Сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээлд эзлэх хувийг нэмэгдүүлэхийн тулд нэмэлт санхүүжилт татаж, хөрөнгө оруулалт хийсээр байна
- Сүү, сүүн бүтээгдэхүүний брэндийн нэр төрлийг нэмэгдүүлж ажилласан.

| | | |
|---|---|---|
| 2.4. | *Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/* | - Балансын гадуурх ажил гүйлгээ байхгүй болно. |
| 2.5. | *Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;* | Зээл / Нийт дүн<br>Авсан зээл: 37,230,000,000<br>Төлсөн зээл: 100,905,786,000 |
| 3. | *Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/* | |

Их хэмжээний хэлцэл:

- Их хэмжээний хэлцэл тухайн тайлант жилд гараагүй.

Сонирхлын зөрчилтэй хэлцэл:

- Аудитын дэлгэрэнгүй тайлангийн тодруулга хэсэгт холбоотой талуудын ажил гүйлгээнээс гадна сонирхлын зөрчилтэй этгээдтэй хийсэн гүйлгээний жагсаалтыг тодруулсан болно. Үүнээс өөр гүйлгээ байхгүй болно.

4. *Цалин урамшууллын мэдээлэл*

Компанийн Цалин урамшууллын бодлого нь Компанийн хэмжээнд баримтлах цалин хөлс, урамшууллын зарчмыг тодорхойлж, ТУЗ, Гүйцэтгэх удирдлага, Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд, нийт ажилтны цалин хөлс, урамшууллын тогтолцооны үндсийг тогтооход чиглэгдэнэ. Компани нь цалин урамшууллын тогтолцоонд дараах суурь зарчмыг баримтална. Үүнд:

- ✓ Зах зээлд өрсөлдөхүйц цалин урамшууллын тогтолцоогоор дамжуулан мэргэшсэн, өндөр ур чадвартай ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах;
- ✓ Ижил үнэлэмж бүхий хөдөлмөрт адил цалин, урамшуулал олгох, гүйцэтгэлийн үнэлгээнд суурилсан цалин урамшууллын хуваарилалт аливаа ялгаварлал, гадуурхал, тэгш бус байдлаас ангид байх;
- ✓ Цалин урамшууллыг ажилтны мэдлэг, ур чадвар болон ажлын байрны үнэлгээ, үнэ цэнд суурилж тогтоох.

**ТУЗ-ийн цалин, урамшуулал**

Цалин урамшууллын бодлогод ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн баталж, гүйцэтгэлийг Компанийн жилийн тайланд тодорхой тусгахаар заасан. ТУЗ-ийн дарга болон гишүүдэд сар бүр тогтмол цалин олгодог ба нэмэлт урамшуулал олгодоггүй. 2024 онд ТУЗ-ийн цалин, урамшууллын хэмжээнд өөрчлөлт ороогүй.

ТУЗ-ийн гишүүдэд 2024 онд олгосон цалин, урамшуулал

| № | ТУЗ-ийн гишүүн | Сарын үндсэн цалин (төг) | Нийт олговол зохих (төг) | Суутгалын дүн (НДШ, ХХОАТ) | Гарт олгосон нийт цалин |
|---|---|---|---|---|---|
| 1 | П.Батсайхан | 10,000,000 | 120,000,000 | 18,712,200 | 101,287,800 |
| 2 | Б.Батбаяр | 6,500,000 | 78,000,000 | 14,512,200 | 63,487,800 |
| 3 | Кеннет Чу | 6,500,000 | 78,000,000 | 23,190,000 | 54,810,000 |
| 4 | Сэн И-Ин | 6,500,000 | 78,000,000 | 23,190,000 | 54,810,000 |
| 5 | Сергей Громов | 6,500,000 | 26,000,000 | 5,244,200 | 20,755,800 |
| | Б.Гантиг | 6,500,000 | 49,214,286 | 9,926,521 | 39,287,764 |
| 6 | Д.Миеэгомбо | 6,500,000 | 26,000,000 | 5,244,200 | 20,755,800 |
| | Б.Гомбо-Эрдэнэ | 6,500,000 | 49,214,286 | 9,926,521 | 39,287,764 |
| 7 | Ё.Гэрэлчулуун | 6,500,000 | 78,000,000 | 13,324,200 | 64,675,800 |
| 8 | Ж.Үнэнбат | 6,500,000 | 78,000,000 | 14,512,200 | 63,487,800 |
| 9 | О.Одбаяр | 6,500,000 | 78,000,000 | 14,512,200 | 63,487,800 |
| | **НИЙТ** | **75,000,000** | **738,428,571** | **155,306,733** | **583,121,839** |

**Гүйцэтгэх удирдлагын цалин, урамшуулал**

Цалин урамшууллын бодлогод Гүйцэтгэх захирлын цалин, урамшуулал үндсэн цалин, урамшууллаас бүрдэж, ТУЗ-тэй байгуулсан гэрээгээр тодорхойлогдохоор заасан.

Компанийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал (хувь хүн) хэрэгжүүлдэг. Гүйцэтгэх захирлыг сонгох, чөлөөлөх, бүрэн эрхийг тогтоох, түүнтэй байгуулах гэрээний нөхцөл, цалин, шагнал урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох нь ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарна.

АПУ ХК-ийн Гүйцэтгэх захирал нь Компанийн охин компаниуд болох АПУ Трейдинг ХХК, М Би Си Азиа Пасифик ХХК, СББ Трейд ХХК, Спирт бал бурам ХХК, ӨМӨЗО-ны Эйпиюү Трейд ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар давхар томилогдон ажилладаг.

Гүйцэтгэх захиралд ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан үндсэн цалингаас гадна “борлуулалтын орлого”, “хүү, татварын өмнөх ашиг”, “зардлын хэмнэлт”, “хүн ба байгууллагын хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэл болон байгууллагын соёлыг сайжруулах ажлуудын үр дүн” гэсэн 4 үндсэн шалгуур үзүүлэлтийг ижил хувийн жинтэйгээр тооцож, урамшуулал олгодог.

**Компанийн ажилтны цалин, урамшуулал**

Цалин урамшууллын бодлогод Компанийн гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд болон нийт ажилтны цалин, урамшууллыг Гүйцэтгэх захирал тогтоодог.

5. *Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл*

**АПУ Групп компанийн бүтэц**




АПУ ХК нь Монгол Улсад бүртгэлтэй 5, гадаад улсад бүртгэлтэй 4 охин компаниийг оруулан нийт 9 охин компани, 1 хараат компанитай ба группийн бүтцэд өөрчлөлт гараагүй.

**Хувьцаа эзэмшигчдийн хурал**

АПУ ХК-ийн эрх барих дээд удирдлага нь хувьцаа эзэмшигчдийн хурал юм.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал цахим хэлбэрээр 2024 оны 04 сарын 30-ны өдрийн 14:00 – 15:30 цагийн хооронд 88.08%-ийн ирцтэй хуралдаж, дараах шийдвэрүүдийг гаргав:

1. АПУ ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан “АПУ групп компани 2023 онд тавьсан зорилтуудаа биелүүлж, амжилттай ажилласан” гэсэн дүгнэлтийг батлав.
2. АПУ ХК-ийн ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгов.
3. АПУ ХК-ийн ТУЗ-ийг дараах бүрэлдэхүүнтэйгээр 3 жилийн хугацаагаар сонгов:

Ердийн гишүүн
1. Пүрэвийн Батсайхан
2. Бүрэнтогтохын Батбаяр
3. Кеннет Чу
4. Сэн И-Ин
5. Батсайханы Гантиг
6. Баярцогтын Гомбо-Эрдэнэ

Хараат бус гишүүн
1. Ёндон-Ойдовын Гэрэлчулуун
2. Одончимэдийн Одбаяр
3. Жигжидийн Үнэнбат

4. АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллыг ТУЗ-ийн дарга 10 сая, ТУЗ-ийн гишүүд 6.5 сая байхаар батлав.

**Төлөөлөн удирдах зөвлөл**

Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт ТУЗ компанийг удирддаг. ТУЗ нь Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, Компанийн дотоод журамд заасан АПУ ХК-ийн ТУЗ-ийн болон түүний охин, хараат компаниудын хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх, үүргийг хэрэгжүүлдэг.

**ТУЗ-ийн бүрэлдэхүүн**

Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хурлаар ТУЗ-ийн бүрэн эрхийг дуусгавар болгож, шинэ бүрэлдэхүүнийг 3 жилийн хугацаатай сонгосноор доорх өөрчлөлт орсон:

- ТУЗ-ийн гишүүн Сергей Громов, Доржийн Миеэгомбо нарын оронд Б.Гантиг, Б.Гомбо-Эрдэнэ нар шинээр сонгогдов.

<table>
<tr><th colspan="2">ТУЗ-ийн бүрэлдэхүүн</th></tr>
<tr><th>2024 оны 04 сарын 30-ны өдрөөс өмнө</th><th>2024 оны 04 сарын 30-ны өдрөөс хойш</th></tr>
<tr><td colspan="2">ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд ТУЗ-ийн дарга<br>ПҮРЭВИЙН БАТСАЙХАН<br>Инженер мэргэжилтэй<br>Шунхлай холдинг ХХК-ийн Ерөнхийлөгч<br>2002 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн дарга<br>Хувьцаа эзэмшил:<br>Хувь хүн: 91,647 ширхэг (0.01%)<br>Шунхлай холдинг ХХК: 602,651,260 ширхэг (56.63%)<br></td></tr>
<tr><td colspan="2">ТУЗ-ийн ердийн гишүүн<br>БҮРЭНТОГТОХЫН БАТБАЯР<br>Эдийн засагч мэргэжилтэй<br>Шунхлай холдинг ХХК-ийн Санхүү эрхэлсэн захирал<br>2013 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн<br>Хувьцаа эзэмшил:<br>Хувь хүн: 82,267 ширхэг (0.01%)<br>Шунхлай холдинг ХХК: 602,651,260 ширхэг (56.63%)<br></td></tr>
<tr><td colspan="2">ТУЗ-ийн ердийн гишүүн<br>КЕННЕТ ЧУ<br>Нягтлан бодогч, менежмент мэргэжилтэй<br>Хайнекен Азиа Пасифик компанийн Ази-Номхон далайн бүсийг хариуцсан Гүйцэтгэх захирал<br>2018 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн<br>Хувьцаа эзэмшил:<br>Хувь хүн: 0 ширхэг (0.00%)<br>Хайнекен Азиа Пасифик Пте Лтд: 266,091,981 ширхэг (25.00%)<br></td></tr>
<tr><td colspan="2">ТУЗ-ийн ердийн гишүүн<br>СЭН И-ИН<br>Хуульч мэргэжилтэй.<br>Хайнекен Азиа Пасифик компанийн Ази-Номхон далайн бүсийн Хууль эрхзүй хариуцсан захирал<br>2020 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн<br>Хувьцаа эзэмшил:<br>Хувь хүн: 0 ширхэг (0.00%)<br>Хайнекен Азиа Пасифик Пте Лтд: 266,091,981 ширхэг (25.00%)<br></td></tr>
</table>

| | | |
|---|---|---|
| | ТУЗ-ийн ердийн гишүүн<br>**СЕРГЕЙ ГРОМОВ**<br>**Инженер мэргэжилтэй**<br>Монгол Даатгал ХК-ийн ТУЗ-ийн дарга<br>2013-2024 онд АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн<br>Хувьцаа эзэмшил: 0 ширхэг (0.00%)<br> | ТУЗ-ийн ердийн гишүүн<br>**БАТСАЙХАНЫ ГАНТИГ**<br>**Бизнесийн удирдлага, менежмент мэргэжилтэй**<br>Дижитал концепт ХХК-ийн Гүйцэтгэх захирал<br>2024 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн<br>Хувьцаа эзэмшил:<br>Хувь хүн: 1,000 ширхэг (0.00%)<br>Шунхлай холдинг ХХК: 602,651,260 ширхэг (56.63%)<br> |
| | ТУЗ-ийн ердийн гишүүн<br>**ДОРЖИЙН МИЕЭГОМБО**<br>**Хуульч мэргэжилтэй**.<br>“ЁС” ХХН-д зөвлөх<br>2022-2024 онд АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн<br>Хувьцаа эзэмшил: 0 ширхэг (0.00%)<br> | ТУЗ-ийн ердийн гишүүн<br>**БАЯРЦОГТЫН ГОМБО-ЭРДЭНЭ**<br>**Хэрэглээний математикч, эдийн засагч, санхүүч мэргэжилтэй**<br>Шунхлай холдинг ХХК-ийн Бизнес хөгжил хариуцсан захирал<br>2024 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн<br>Хувьцаа эзэмшил:<br>Хувь хүн: 100 ширхэг (0.00%)<br>Шунхлай холдинг ХХК: 602,651,260 ширхэг (56.63%)<br> |
| | ТУЗ-ийн хараат бус гишүүн<br>**ЁНДОН-ОЙДОВЫН ГЭРЭЛЧУЛУУН**<br>**Эдийн засагч мэргэжилтэй**<br>Нээлттэй хот ТББ-ын үүсгэн байгуулагч<br>2017 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн<br>Хувьцаа эзэмшил: 0 ширхэг (0.00%)<br> | |
| | ТУЗ-ийн хараат бус гишүүн<br>**ОДОНЧИМЭДИЙН ОДБАЯР**<br>**Багш, эрх зүйч мэргэжилтэй**<br>Ард даатгал ХК, Ард холдинг ХХК, Монгол шуудан ХК-уудын ТУЗ-ийн гишүүн<br>2021 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн<br>Хувьцаа эзэмшил: 0 ширхэг (0.00%)<br> | |
| | ТУЗ-ийн хараат бус гишүүн<br>**ЖИГЖИДИЙН ҮНЭНБАТ**<br>**Эдийн засагч мэргэжилтэй**<br>2013 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн<br>Хувьцаа эзэмшил: 0 ширхэг (0.00%)<br> | |
| | **ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан**<br>ТУЗ нь танхимаар, танхим-цахим хосолсон, эчнээ санал хураалтын хэлбэрээр нийт 13 удаа, дунджаар 99%-ийн ирцтэй хуралдаж, бүрэн эрхийнхээ хүрээнд нийт 58 тогтоол гаргав. | |

| Хурлын | | | | Баталсан тогтоолын тоо | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Д/д | Огноо | Ирц | Нийт | АПУ ХК | АПУ Дэйри ХХК | АПУ Трейдинг ХХК | М Би Си Азиа Пасифик ХХК | СББ Трейд ХХК | Спирт бал бурам ХХК | ОХУ-ын Гранд ХХК | ОХУ-ын Гранд Ист ХХК | БНХАУ ӨМӨЗО-ны Эйпиюу трейд ХХК |
| | | | | ТУЗ-ийн хурал | Хувьцаа эзэмшигчдийн хурал | | | | | | | |
| 1 | 2024.02.16 | 100% | 13 | 3 | 3 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 |
| 2 | 2024.03.20 | 100% | 2 | 1 | 1 | | | | | | | |
| 3 | 2024.04.15 | 100% | 13 | 5 | 2 | 1 | 3 | 1 | 1 | | | |
| 4 | 2024.05.10 | 89% | 3 | 2 | | | | | 1 | | | |
| 5 | 2024.06.24 | 100% | 1 | | | | 1 | | | | | |
| 6 | 2024.07.08 | 100% | 1 | 1 | | | | | | | | |
| 7 | 2024.07.23 | 100% | 2 | 2 | | | | | | | | |
| 8 | 2024.08.01 | 100% | 6 | 4 | 2 | | | | | | | |
| 9 | 2024.09.04 | 100% | 1 | 1 | | | | | | | | |
| 10 | 2024.10.23 | 100% | 5 | 1 | | 1 | 1 | 1 | 1 | | | |
| 11 | 2024.11.29 | 100% | 2 | 2 | | | | | | | | |
| 12 | 2024.12.10 | 100% | 8 | 1 | | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 |
| 13 | 2024.12.25 | 100% | 1 | 1 | | | | | | | | |
| | Нийт | 99% | 58 | 24 | 8 | 4 | 7 | 4 | 5 | 2 | 2 | 2 |

Жилийн турш ТУЗ-ийн гишүүн бүрийн хуралд оролцсон ирц




**ТУЗ-ийн дэргэдэх хороод**

Компанийн тухай хуулийн 81.2-т заасны дагуу ТУЗ-ийн дэргэд Аудитын, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хороо ажилладаг бөгөөд хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүн юм.

Тайлант хугацаанд ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй ба хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хурлаар ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг шинээр сонгосны дараа 2024 оны 05 сарын 10-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар хороодын бүрэлдэхүүнийг улираан томилсон.

ТУЗ-ийн дэргэдэх хороод Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, хороодын журамд заасан эрх, үүргийг хэрэгжүүлэн ажиллав.

| ТУЗ-ийн хороо | Хуралдсан тоо | Бүрэлдэхүүн | ТУЗ-ийн гишүүний хэлбэр | Нэрс |
|---|---|---|---|---|
| **Аудитын хороо** | **3** | Хорооны дарга | Хараат бус гишүүн | Ж.Үнэнбат |
| | | Гишүүн | Ердийн гишүүн | Сэн И-Ин |
| | | Гишүүн | Хараат бус гишүүн | О.Одбаяр |
| **Нэр дэвшүүлэх хороо** | **1** | Хорооны дарга | Хараат бус гишүүн | О.Одбаяр |
| | | Гишүүн | Ердийн гишүүн | П.Батсайхан |
| | | Гишүүн | Хараат бус гишүүн | Ё.Гэрэлчулуун |
| **Цалин урамшууллын хороо** | **1** | Хорооны дарга | Хараат бус гишүүн | Ё.Гэрэлчулуун |
| | | Гишүүн | Ердийн гишүүн | Ж.Үнэнбат |
| | | Гишүүн | Хараат бус гишүүн | Кеннет Чу |

**ТУЗ-ийн нарийн бичгийн дарга**

ТУЗ-ийн хурлын 2024 оны 09 сарын 04-ний өдрийн тогтоолоор ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Чадраабалын Ариунсангийн оронд Базаррагчаагийн Сарантунгалагийг томилсон.

| ТУЗ-ийн нарийн бичгийн дарга | |
|---|---|
| **2024 оны 09 сарын 04-ний өдрөөс өмнө** | **2024 оны 09 сарын 04-ний өдрөөс хойш** |
| **ЧАДРААБАЛЫН АРИУНСАН**<br>**ОУ худалдаа, Бизнесийн удирдлага мэргэжилтэй.**<br>2012-2024 онд АПУ ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга<br>Хувьцаа эзэмшил: 1,400 ширхэг (0.00%)  | **БАЗАРРАГЧААГИЙН САРАНТУНГАЛАГ**<br>**Бизнесийн удирдлага мэргэжилтэй**<br>2024 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга<br>Хувьцаа эзэмшил: 2,405 ширхэг (0.00%)  |

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь 2024 онд Компанийн ТУЗ-ийн ажлын албаны дарга бөгөөд Комплайнсын нэгжийн удирдлагын үүргийг гүйцэтгэж ажиллав.

**Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн үнэлгээ**

АПУ ХК-аас Кодексийн хэрэгжилтийн өөрийн үнэлгээг 2024 оны эцэст нэг удаа хийсэн ба СЗХ-ны Компанийн засаглал, комплайнсын хэлтсээс хянан баталгаажуулсан үр дүнг дор үзүүлэв.

АПУ ХК-ИЙН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХЯНАН БАТАЛГААЖИЛТ

| | | | 2024 оны I хагас жил | | 2024 оны эцэс | |
|---|---|---|---|---|---|---|
| **№** | **Гарчиг** | **Авбал зохих оноо** | **Үнэлсэн оноо** | **Үнэлгээний хувь** | **Үнэлсэн оноо** | **Үнэлгээний хувь** |
| 1 | ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт | 12 | 7 | 58% | 10 | 83% |
| 2 | ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг | 10 | 10 | 100% | 10 | 100% |
| 3 | Тайлагнал, мэдээллийн ил тод байдал | 6 | 6 | 100% | 6 | 100% |
| 4 | Аудит, хяналтын тогтолцоо | 6 | 6 | 100% | 6 | 100% |
| 5 | Эрсдэлийн удирдлага | 8 | 8 | 100% | 8 | 100% |
| 6 | Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал | 6 | 5 | 83% | 6 | 100% |
| 7 | Оролцогч талуудын эрх ашиг | 8 | 8 | 100% | 8 | 100% |
| 8 | Компанийн соёл | 6 | 5 | 83% | 5 | 83% |
| 9 | Хувьцаа эзэмшигчдийн эрх | 10 | 9 | 90% | 9 | 90% |
| | **Нэгдсэн дүн** | **72** | **64** | **89%** | **68** | **94.4%** |
| | **Үнэлгээний тайлбар** | | **2. Дунд засаглалтай** | | **1. Засаглал хэвийн буюу эрсдэлгүй** | |
| | **Засаглалын зэрэглэл** | | **17-р байр** | | **4-р байр** | |

АПУ ХК кодексийн хэрэгжилтийн үнэлгээгээр Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй нээлттэй хувьцаат компаниудаас 2024 оны жилийн эцсийн байдлаар 94.4%-ын үнэлгээгээр дөрөвдүгээр байранд эрэмбэлэгдлээ.

6. *Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл*

**Эрсдэлийн удирдлага**

Салбарын болон компанийн үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй томоохон эрсдэлүүдийг тодорхойлсноос хамгийн өндөр ач холбогдолтой 5 эрсдэлийг дор үзүүлэв.

Эрсдэлээс урьдчилан сэргийлэх, оновчтой удирдахын тулд шаардлагатай хариу арга хэмжээнүүдийг тодорхойлж, нэгдсэн удирдлага зохион байгуулалтын дагуу анхаарч ажиллав.

Нэн ялангуяа урт болон богино хугацааны санхүүг төлөвлөх, процессыг сайжруулах зорилтын хүрээнд дотооддоо олон төрлийн төсөл, хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж, үйлдвэрлэл, үйл ажиллагааны тасалдалгүй байдлыг хангах, хөрөнгө оруулагч, ажилтан, хэрэглэгч, нийлүүлэгчид, компанийн бүхий л оролцогч талуудын сэтгэл ханамжийг дээшлүүлж, үнэ цэнийг түгээхэд төвлөрлөө.

**Гадаад хүчин зүйлсийн нөлөөлөл ба томоохон эрсдэлүүд**




7. *Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/*

**Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо**[1]




Өнгөрөгч онтой харьцуулбал хувьцаа эзэмшигчийн тоо 55%-аар өссөн бөгөөд хувьцаат компаниуд дунд дөрөвдүгээрт эрэмбэлэгдэж байна.

**Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид**[2]

| Д/д | Хувьцаа эзэмшигч | 2023 оны эцэс | | 2024 оны эцэс | |
|---|---|---|---|---|---|
| | | Хувьцааны тоо ширхэг | Нийт гаргасан хувьцаанд эзлэх хувь | Хувьцааны тоо ширхэг | Нийт гаргасан хувьцаанд эзлэх хувь |
| 1 | Шунхлай Холдинг ХХК | 598,230,342 | 56.22 | 602,651,260 | 56.63 |
| 2 | Хайнекен Азиа Пасифик Пте Лтд | 266,091,981 | 25.00 | 266,091,981 | 25.00 |
| 3 | Степпе Бэвэриж КФТ | 112,264,896 | 10.55 | 59,351,609 | 5.58 |
| 4 | Бусад | 87,808,918 | 8.25 | 136,086,703 | 12.79 |

Өмнөх онтой харьцуулбал нөлөө бүхий хувьцаа эзэмшигч Шунхлай холдинг ХХК-ийн эзэмшлийн хувьцаа 4,420,910 ширхэг буюу 0.42%-аар нэмэгдсэн бол Степпе Бэвэриж КФТ-ийн эзэмшлийн хувьцаа 52,913,287 ширхэг буюу 4.97%-аар буурч олон нийтийн эзэмшилд шилжжээ.

[1] ҮЦТХТ ХХК-аас гаргасан 2024.12.31-ний өдрийн байдлаарх үнэт цаасны төвлөрлийн судалгааны мэдээлэл
[2] ҮЦТХТ ХХК-аас гаргасан 2024.12.31-ний өдрийн байдлаарх үнэт цаас эзэмшигчдийн судалгааны мэдээлэл

| | |
|---|---|
| *8.* | *Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл* |
| | Тайлант хугацаанд олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй. |
| *9.* | *Ногдол ашгийн мэдээлэл* |

**Ногдол ашгийн бодлого**

Ногдол ашгийн бодлогоор Компани дор дурдсан нөхцөлд цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилна:

- ✓ Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх,
- ✓ Ногдол ашиг төлсний дараа Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, түүний татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс их байх,
- ✓ Компани эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх.

Ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэрийг ТУЗ гаргах ба санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор, хагас жилээр ногдол ашиг хуваарилах тохиолдолд хагас жилийн санхүүгийн тайлан гарснаас хойш 30 хоногийн дотор хэлэлцэн шийдвэрлэнэ.

ТУЗ нь ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэвэл энэ тухайгаа хувьцаа эзэмшигчдийн хуралд заавал тайлагнана.

**Ногдол ашиг хуваарилалт**

АПУ ХК-ийн ТУЗ-өөс 2024 оны нийлбэр дүнгээр компанийн хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцаанд нийт 120 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн болно.

| Тайлант хугацаа | ТУЗ-өөс ногдол ашиг зарласан өдөр | Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг | Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гарах бүртгэлийн өдөр | Ногдол ашиг төлөхөөр тогтоосон сүүлийн өдөр | Ногдол ашгийг ҮЦТХТ ХХК-аар зуучлуулан төлсөн/төлөх өдөр |
|---|---|---|---|---|---|
| 2024 оны I хагас жил | 2024.08.01 | 55 төг | 2024.08.20 | 2025.02.10 | 2024.10.02 |
| 2024 оны II хагас жил | 2025.02.10 | 65 төг | 2025.04.04 | 2025.08.19 | 2025.04.30 |
| НИЙТ | | 120 төг | | | |

Ногдол ашгийн төлбөрийг нийт хувьцааны таваас доош хувийг эзэмшигчдэд “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аар зуучлуулан, таваас дээш хувийг эзэмшигчдэд компаниас шууд төлөх замаар мөнгөн хэлбэрээр олгож байна.



| | |
|---|---|
| *10.* | *Үнэт цаас гаргагчаас тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл* |
| | Нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайланг Тогтвортой хөгжлийн тайланд дэлгэрэнгүй тусгасан бөгөөд үүнд залуус, иргэдийн эрүүл мэнд, чөлөөт цагийг дэмжих зорилгоор Парис 2024 олимп, паралимын шууд дамжуулалт, Үндэсний дээд лиг, FC Ulaanbaatar багийн үйл ажиллагаа, Монгол бөхийн өргөөний барилдаанууд, соёлын өвийг хамгаалах хөтөлбөрүүд зэрэг спорт, соёлын үйл ажиллагааг тогтмол ивээн тэтгэж байгааг дурдаж болно. |

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

| | |
|---|---|
| Овог, нэр: Цэвээнжавын Эрдэнэбилэг<br>Албан тушаал: “АПУ” ХК-ийн гүйцэтгэх захирал<br><br>Гарын үсэг: ……………………………………<br><br>*(Тамга/тэмдэг)*<br>МОНГОЛ УЛС<br>APU COMPANY<br>Absolute. Pure. Unique.<br>АПУ ХУВЬЦААТ КОМПАНИ<br>2702673 1116224357 | Овог, нэр: ……………………<br>Албан тушаал: “Кэй Пи Эм Жи Аудит” ХХК-ийн гүйцэтгэх захирал<br><br>Гарын үсэг: ……………………………………<br><br>*(Тамга/тэмдэг)* |

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Базаррагчаагийн Сарантунгалаг
Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг: ……………………………………